



УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ

2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ
2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн тайлан

Агуулга

	Хуудас
Компанийн танилцуулга	3
Онцлох үйл явдлууд	4
Стратеги, хэтийн төлөв	6
Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд	7
NI 43-101 Техникийн тайлан – геологийн ба үйлдвэрлэлийн нөөц	7
Хөндий Эрдсийн Дүүрэг	8
Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуул	11
Хөрөнгө оруулалт	16
Санхүүгийн тайлангийн онцлох мэдээлэл	16
Үйл ажиллагааны хэлэлцүүлэг	17
4-р улирлын мэдээлэл	19
Улирлын үр дүнгийн хураангуй	19
Төлбөр гүйцэтгэх чадвар болон капитал нөөц	19
Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл	20
Гэрээгээр хүлээсэн үүрэг	20
Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг	20
Балансаас гадуурх зохицуулалт	21
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тооцоолол	21
Санхүүгийн хэрэглүүр ба бусад эрсдэл	22
Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт	23
Мэргэшсэн этгээд	24
Бусад мэдээлэл	24

Энэхүү 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар боловсруулсан Удирдлагын Хэлэлцүүлэг ба Дүн Шинжилгээ (“УХДШ”) нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” эсвэл “Корпораци” гэх)-ийн 2022, 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн тайлан, тэдгээрийн тодруулгуудын хамт хэрэглэгдэх бөгөөд тус Корпорацийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд хамаарна. Корпорацийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Канад доллараар илэрхийлж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулсан

Энэхүү хэлэлцүүлэг нь “Урьдчилсан таамаглал” гэж үзэж болохуйц тодорхой мэдэгдлүүдийг агуулсан болно. Түүхэн баримтат мэдэгдлээс бусад энэхүү тайланд дурдагдах Баянхөндий ордын олборлолт болон боломжит нөөц, хайгуулын өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагаа, төсөвт санхүүгийн үр дүн, Корпорацийн хүлээж буй үйл явдал, хөгжүүлэлт зэрэг нь алс хэтийг угтан харсан мэдэгдлүүд юм. Ийнхүү урьдчилсан таамаглал (Корпораци, түүний охин компаниудын тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа, эдийн засаг, зах зээлийн ерөнхий нөхцөл байдал, ашигт малтмалын үнэ, бодит нөөц тогтоолт зэрэгтэй холбоотой төсөөллүүдийг багтаах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй)-д тулгуурласан алсыг харсан мэдэгдлүүдэд илэрхийлсэн хүлээлтүүд нь ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй бөгөөд бодит үр дүн, хөгжүүлэлт нь зах зээлийн үнэ, хайгуул ба үнэлгээний үр дүн, капитал болон санхүүгийн тасралтгүй хүртээмжтэй байдал, эдийн засаг, зах зээл, бизнесийн ерөнхий нөхцөл байдал гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан тэдгээр алс хэтийн төсөөллөөс материаллаг байдлаар ялгаатай байж болно.

Дээр тодорхойлсон эрсдэлийн хүчин зүйлс нь Корпорацид нөлөөлөхүйц бүхий л хүчин зүйлсийг хараахан бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй. Нэмэлт хүчин зүйлсийг Корпорацийн www.sedarplus.ca-д тавигдсан Корпорацийн жилийн мэдээ, тайлангийн “Эрсдэлийн хүчин зүйлс” хэсэгт тэмдэглэсэн болно.

Канад Улсын үнэт цаасны хуулиар тодорхойлогдох энэхүү УХДШ-д тусгасан санхүүгийн аливаа хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг Корпорацийн удирдлага тус УХДШ гарах өдрөөр баталсан болно. Ирээдүйтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хүлээж буй болон төлөвлөж буй ажлын талаар мэдээлэх зорилгоор санхүүгийн хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг өгч байгаа юм. Ийм хэтийн төлөв, ирээдүйн мэдээллүүдийг энэхүү УХДШ-д тусгаснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Энэхүү УХДШ-г бэлтгэхдээ Компани нь НББ-ийн хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий зарчмуудаас гадна “Хайгуул, үнэлгээний зардал”-ын талаар багтаасан. Хайгуул, үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой капиталжуулсан болон ашиглалтын зардлаас бүрдэх хайгуул, үнэлгээний зардал нь санхүүгийн тайлангийн хугацаанд компанийн үл хөдлөх хөрөнгөд оруулсан нийт хөрөнгө оруулалтын үнэ цэнтэй үзүүлэлт гэж удирдлага үзэж байна. Энэхүү НББийн хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий зарчмуудаас гаднах санхүүгийн гүйцэтгэлийн хэмжүүрийг СТОУС-ын дагуу шууд харьцуулж болох хэмжүүртэй нарийвчилсан уялдах мэдээллийг УХДШ-ний 15-р хуудсаас үзнэ үү. Энэхүү УХДШ-д тусгагдсан НББ-ийн хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий зарчмуудаас гаднах санхүүгийн гүйцэтгэлийн хэмжүүр нь хөрөнгө оруулагчдад нэмэлт мэдээлэл өгөх зорилготой бөгөөд СТОУС-ын дагуу стандартчлагдсан утга агуулаагүй тул бусад үнэт цаас гаргагчидтай харьцуулах боломжгүй, СТОУС-ын дагуу бэлтгэсэн гүйцэтгэлийн хэмжүүрийг орлуулах буюу тусад нь тодорхойлох боломжтой.

Компанийн танилцуулга

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсын хязгаарлагдмал хайгуул хийгдсэн өндөр хэтийн төлөв бүхий бүсэд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонтогийн хөрөнгийн бирж (TSX:ERD) болон Монголын хөрөнгийн биржид (MSE:ERDN) давхар бүртгэлтэй.

Компани нь Монгол Улсын баруун урд хэсэгт хайгуул хийх эрх бүхий 1 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлүүд дээр хийсэн судалгааны үр дүнд Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий Эрдсийн Дүүрэг нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогенийн бүс дэх Транс Алтайн Терреинд байрладаг. Төв Азийн Орогенийн Бүс нь БНХАУ болон Уралын нуруудын дагуу 2,500 км хамран оршдог. Энэхүү бүс нь Узбекистаны Мурунтау зэрэг дэлхийн хамгийн том алтны ордыг багтаан, хэд хэдэн порфир, порфиртой холбоотой алт, зэсийн ордуудыг агуулдаг. Энэхүү бүсийн дагуу Монгол Улсын зүүн өмнөд хэсэгт Хөндий Эрдсийн Дүүргээс 650 км зайд Рио Тинтогийн Оюу Толгой зэс-алтны орд мөн байрладаг.

Эрдэнэ Ресурс Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хайгуул хязгаарлагдмал хийгдсэн бүсэд 20 гаруй жилийн турш хайгуулын үйл ажиллагаа эрхлэн, Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Энэхүү хугацаанд Эрдэнэ Ресурс нь Алтан Нар, Баянхөндий зэрэг эпитеpmаль алтны ордууд, Улаан, Хар Морь зэрэг алтны төслүүд, Зуун Мод молибдени-зэсийн порфирийн ордоос гадна хэд хэдэн хэтийн төлөв бүхий бүсүүд, хайгуулын талбайг тодорхойлсон. Эдгээр нээлтүүд нь Хөндий Эрдсийн Дүүргийн цөм бөгөөд баруун хойд зүгт 50*100 км талбайг хамран оршдог.

2023 оны 1-р сард Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын уул уурхайн томоохон олборлогч болох Монголиан Майнинг Корпорэйшн ("MMC")-тэй Хөндий Эрдсийн Дүүргийн хөгжүүлэх зорилгоор стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан. Түншлэлийн гэрээний хүрээнд MMC нь гурван үе шаттайгаар 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК ("ЭМ")-ийн 50%-тай тэнцэх хувьцааг эзэмших нөхцөлтэй. Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-г эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн орчимд 5 км-ийн талбайд эзэмших тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр ("Net smelter return" буюу "NSR") (цаашид "БОТ" гэх) авна. Мөн Эрдэнэ Ресурс нь Зуун Мод молибден-зэсийн төслийг 100% эзэмшсэн хэвээр байна. Стратегийн түншлэлийн хүрээнд хийсэн хөрөнгө оруулалтын гэрээ 2024 оны 1-р сарын 23-ны өдөр албан ёсоор дуусгавар болсон.

Стратегийн түншлэлийн гэрээний дараагаар, Баянхөндий алтны төслийн шинэчилсэн ТЭЗҮ ("Feasibility Study" буюу "FS") болон Уурхайн ашиглалтын хугацаа ("Life of Mine" буюу "LOM") (цаашид "УАХ")-ны төлөвлөгөөг шинэчилж 8 сард танилцуулсан. 2023 онд шинэчилсэн ТЭЗҮ нь 2020 оны ТЭЗҮ-г боловсруулсан судалгааны баг гүйцэтгэсэн ба Баянхөндий ордын шинэчилсэн нөөц, түүнчлэн шинээр нээн илрүүлсэн Хар Морь талбайн нөөцийг багтаасан. 2020 оны ТЭЗҮ-тэй харьцуулахад олборлох алтны хэмжээ 25%-иар өссөн байна. Нэмэлт зураг төсөл, инженерчлэлийн ажлын хүрээнд үйлдвэрийн боловсруулалтыг жилд 650,000 тонн болгон нэмэгдүүлж, өмнөх судалгаанаас 8%-иар өссөн байна. 2023 онд боловсруулсан шинэчилсэн ТЭЗҮ-ээр эдийн засгийн өгөөж өндөр гарсан. Төслийн татварын дараах цэвэр өнөөгийн үнэ цэн ("NPV5%") 196 сая ам.доллар, нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг ("AISC") нь \$869 ам.доллар, анхан шатны хөрөнгө оруулалтын хэмжээ \$100 сая ам.доллар байна.

Өнгөрсөн 12 сарын хугацаанд Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд төслийн нарийвчилсан зураг төсөл, барилгын зөвшөөрлүүдийг авч тоног төхөөрөмжийн захиалгуудыг хийсэн. 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Баянхөндий төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх албан ёсны шийдвэрийг танилцуулсан. Мөн барилгын ажилд шаардагдах санхүүжилтийн талаарх мэдээллийг 2024 оны 2 сарын 8-ны өдөр танилцуулсан.

Бүтээн байгуулалтын албан ёсны шийдвэрийг төслийн барилгын бэлтгэл ажил дууссанаар (2023 оны хоёрдугаар хагас) гаргав. Бүтээн байгуулалт 12% гүйцэтгэлтэй явж байгаа ба энэ хугацаанд боловсруулах үйлдвэрийн бутлуур, бетон зуурмагийн үйлдвэр, түлшний агуулах, түр кемп, барилгын зам, талбайн тэгшилгээ, нарийвчилсан газар шорооны ажлууд, томоохон төмөр бетон суурь, баганын суурилуулалт зэрэг байгууламжуудыг барьсан. 2024 оны 2-р сард барилгын ажил идэвхжсэнээр, боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 2024 оны эцэст дуусаж, 2025 оны 1-р улиралд улсын комисст хүлээлгэж өгөхөөр төлөвлөж байна. Төслийн хуваарийн дагуу 2025 оны 2-р улиралд анхны алтыг гаргахаар төлөвлөсөн.

2023 онд хайгуулын хөтөлбөрийн хүрээнд Хар Морь талбайд 1000 тууш метрийн өрөмдлөг хийсэн ба нийт 20км²-ийг хамарсан Хар Морь талбайн 9км² хэсэгт цахилгаан туйлшралын геофизикийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Хөтөлбөрөөр 18 кооног өрөмдсөний 16 кооногт аномаль алт (0.1 г/т -с дээш алтны агуулга бүхий) болон индикатор элемент огтолж, газрын дөт гүнд хэд хэдэн талбайд хүдэржилт огтолсон. Газрын дөт гүнд, өндөр агуулгатай Хар Морин Дэлийн хүдэржилтийн трендийг илрүүлэхэд Хар Морь ордын онцлог шинж чанар болох алт, сурьма, хүнцэл болон молибден нь чухал үүрэг гүйцэтгэсэн. Нэмэлтээр, газрын дөт гүнд супергэнээр баяжуулсан исэлдсэн бүсүүдийг судлахаар Хар Морь болон Улаан талбайг хамарсан 500 гаруй метрт суваг малталтын ажлыг гүйцэтгэсэн. Хэд хэдэн сувагт аномаль хүдэржилт илрүүлснээр ирээдүйн судалгааны бүсүүдийг тодорхойлов.

Ази тивд хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибден-зэсийн ордуудын нэг болох Зуун Мод төслийн хайгуулыг амжилттай ахиулж байна. 2023 оны 5 сард тус төслийн талбайд 4,100 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн. Өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн кооноогоор өнөөгийн нөөцийн хязгаарыг тэлсэн бөгөөд ордын төв бүсийн интервалуудад дунджаас өндөр агуулга огтолсон. Мөн, ордоос хойд зүгт 1.7 км зайд нөөцийн зэрэг бүхий хүдэржилт илэрсэн нь энэхүү томоохон молибден-зэсийн цогцолбор нь бүх чиглэлд нээлттэйг илтгэж байна. 2021 оны сүүлээр RPMGlobal компанийн гүйцэтгэсэн төслийн тооцооллын үнэлгээнд үндэслэн зах зээл, техник, эдийн засгийн судалгааг ирэх саруудад хийж дуусгана.

Эрдэнэ Ресурс нь цаашид Төв Азийн Орогенийн Бүсийн хүрээнд алт зэсийн судлагдаагүй хэсэгт тусгай зөвшөөрлийн талбайд хөрөнгө оруулалт хийн, нөөцийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. Хөндий Эрдсийн Дүүрэг нь зэс-молибденийн порфир, завсрын сульфиджилт/карбонат суурь бүхий металлын ордууд, сульфиджилт багатай эпитеpmаль алт, алт-мөнгөний орд гэх суурь ба үнэт металлын бүрэн спектрийг агуулдаг. Эрдэнэ Ресурс нь урт хугацаанд Монголын баруун өмнөд хэсэгт үйл ажиллагаа явуулж буй компани бөгөөд MMC-тэй хийсэн түншлэлийн хүрээнд энэхүү өндөр хэтийн төлөв бүхий талбайг үргэлжлүүлэн тэлэх зорилтыг баримтлан ажиллаж байна.

Онцлох үйл явдлууд

Баянхөндий Алтны Төсөл

- Баянхөндий төслийн бүтээн байгуулалтын шийдвэрийг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр гаргасан.
 - Төслийн инженер, худалдан авалт, барилгын ("EPC") цогц гэрээг Монголын барилгын тэргүүлэгч компани, MMC-ийн харилцан хамаарал бүхий MCS Property LLC ("MCSP")-тэй байгуулсан.
 - Эрчим хүчний үйлчилгээ, эрчим хүч үйлдвэрлэх урт хугацааны гэрээлэгчээр MMC-ийн харилцан хамаарал бүхий MCS International LLC ("MCSI")-г сонгон, эрчим хүч худалдан авах гэрээ ("PPA") байгуулсан.
 - 2024 оны 2-р сард барилгын ажил идэвхжсэнээр боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 2024 оны эцэст дуусаж, 2025 оны 1-р улиралд улсын комисст хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна. Төслийн хуваарийн дагуу 2025 оны 2-р улиралд анхны алтыг гаргахаар төлөвлөсөн.
- Баянхөндий төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл болон томоохон худалдан авалтыг эцэслэсэн.
 - Төслийн талбайн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд түр байгууламжууд, үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн суурийн ажлууд дууссан – төслийн барилгын явц 12% гүйцэтгэлтэй байна.
 - Төслийн талбайд компанийн болон гүйцэтгэгч байгууллагын 330 орчим ажилтан ажиллаж байна – Хөдөлмөрийн чадвар алдагдах осол бүртгэгдээгүй.
 - Урт хугацааны болон голлох тоног төхөөрөмжийн захиалгууд хэвийн явагдаж байгаа ба 2023 оны 4-р улиралд эхний хүргэлтийг хүлээн авсан.
- Баянхөндий NI 43-101 Техникийн тайлангийн онцлох мэдээлэл (Алтны үнийг US\$1,800/унцаар төсөөлсөн)
 - Суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (NPV5% буюу 5% хорогдуулалт бүхий) \$170 сая.доллар, дотоод өгөөжийн түвшин (IRR) 35% тооцоологдсон. Өнөөгийн алтны ханш буюу US\$2,000/унц-д тулгуурлан тооцвол тус бүр \$223 ам.доллар болон 42% болж өсөх үзүүлэлттэй.

- Баянхөндий ордын ашиглалтын хугацаанд хүү, татвар болон элэгдлийн өмнөх орлого (“EBITDA”) нийт \$451 сая ам.доллар бөгөөд өнөөгийн алтны ханш (US\$2,000/унц)-д тулгуурлавал \$540 сая ам.доллар хэмээн тооцоологдсон.
- Нийт 476,000 унц алт олборлох тооцоолол нь 2020 оны ТЭЗҮ-тэй харьцуулахад 25%-иар өссөн үзүүлэлт бөгөөд металл авалт 93%-тай байна.
- Нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг (“AISC”) нь \$869 ам.доллар, анхан шатны хөрөнгө оруулалтын хэмжээ \$88 сая ам.доллар ба үүн дээр 12%-ийн болзошгүй зардал болон \$2 сая долларын үйлдвэрлэлийн өмнөх зардлууд нэмэгдэнэ.
- 2.6 г/т дундаж агуулга бүхий 674,700 унц алт, 1.38 г/т дундаж агуулга бүхий 319,000 унц мөнгөний баттай болон бодитой геологийн нөөц (“M&I”) тодорхойлсон.
- 4 г/т дундаж агуулга бүхий 513,700 унц алт болон 1.7 г/т дундаж агуулга бүхий 220,500 унц мөнгөний батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“P&P”)-ийг тодорхойлсон.
- Жилд олборлох алтны дундаж хэмжээ нь эхний 2-5 жилийн хугацаанд 86,900 унц байх ба уурхайн ашиглалтын хугацаанд жилд дунджаар 74,200 унц алт олборлоно.
- Төслийн талбайн зэргэлдээ өндөр агуулга бүхий талбай, шинэ нээлтүүд нь ирээдүйд нөөц тэлэх магадлалыг нэмэгдүүлнэ.
- Орон нутаг болон оролцогч талуудын хамтын ажиллагааны ажлуудын хүрээнд:
 - Хүнд машин механизмын операторын сургалтыг зохион байгуулж, Баянхонгор аймгийн 80 иргэдийг хамруулав. Төгсөгчид MMC-д операторын ажлын байраар хангагдаж ажиллаж байгаа бөгөөд 2025 онд Баянхөндий төслийн олборлолт эхлэмэгц төсөл дээр ажиллахаар төлөвлөж байна.
 - Ундны усны хангамжийг сайжруулах, нийтийн боловсон ариун цэврийн байгууламж барих зэрэг орон нутгийн хөгжлийн томоохон төслүүдийг гүйцэтгэсэн.
 - Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний дагуу 2023 онд төлөвлөсөн орон нутгийн хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн.

Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуулын хөтөлбөр

- 2023 оны алтны хайгуулын хөтөлбөрийн хүрээнд Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд өрөмдлөг хийж гүйцэтгэсэн:
 - 1040 тууш метрийн 18 цооног өрөмдсөнөөс 16 цооногт аномаль алт ба/эсвэл индикатор элементүүд огтолсон.
 - 9 км² талбайг хамарсан цахилгаан туйлшралын геофизикийн судалгаа хийж, ирээдүйн өрөмдлөгийн бүсүүдийг тодорхойлсон.
 - Хар Морин Дэл талбайд огтолсонтой төстэй газрын дөт гүнд супергэнээр баяжуулсан исэлдсэн бүсүүдийг судлахаар 500 гаруй метрт суваг малталтын ажлыг гүйцэтгэсэн. Хэд хэдэн талбайд аномаль хүдэржилт илэрсэн.
- Зуун Мод молибден-зэсийн ордод 4100 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн.
 - Одоогийн NI 43-101 тайланд багтсан эрдсийн нөөцийн хязгаарыг тэлсэн.
 - Ордоос хойд зүгт 1.7 км зайд өндөр агуулга бүхий хүдэржилтийг огтолсон нь нөөцийг нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна.

Компанийн тухай

- 2024 оны 1 сарын 23-ны өдөр Монголиан Майнинг Корпорэйшн (“MMC”)-тэй байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээг эцэслэв:
 - Баянхөндий төслийг эзэмшдэг ЭМ компанийн 50%-г эзэмших нөхцөлөөр MMC нь 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.
 - Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-ийг эзэмшихээс гадна Хөндий Эрдсийн Дүүргийн 400,000 унц давсан олборлолтоос 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх) авах нөхцөлтэй. Мөн Зуун Мод молибден-зэсийн ордыг 100% эзэмшсэн хэвээр байна.
- Баянхөндий төслийн санхүүжилтийг стратегийн түнш MMC-ээс татан төвлөрүүлнэ:
 - Эрдэнэ Ресурс болон MMC хамтран эзэмшдэг ЭМ-д хувь эзэмшигчийн зээл хэлбэрээр 80 сая ам.доллар хүртэлх төслийн санхүүжилтийг татан төвлөрүүлнэ.

- 5 жилийн хугацаатай, 13.8%-ийн хүүтэй ба зээлийн хугацаа дуусахад бүрэн төлсөн байх нөхцөлтэй.
- Барьцаа хөрөнгө нь Эрдэнэ Ресурсийн ЭМ дахь 50%-ийн эзэмшил байна.
- 2023 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болсон тайлант жилийн хугацаанд \$522,043 цэвэр орлоготой ажилласан ба энэ нь 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр \$5,986,237 алдагдалтай байв.
 - Капиталжуулсан зардал оролцуулсан хайгуул болон үнэлгээний өртөг нь 2023 оны 12 сарын 31-ний байдлаар \$847,010 байсан нь 2022 оны мөн үеийн капиталжуулсан зардал оролцуулсан \$3,798,676-тай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэ нь ММС-тэй байгуулсан Стратегийн түншлэлийн хүрээнд ЭМ дахь хяналтыг алдсанаар ЭМ-ын үйл ажиллагааг хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт болгон бүртгэж, Эрдэнэ Ресурсийн бүсийн хайгуулын ажлуудын зардлыг хэсэгчлэн тэнцүүлснээс үүдэлтэй.
 - Капиталжуулсан зардал оролцуулсан хайгуул болон үнэлгээний өртөг болон СТОУС-н өмчийн аргаар бүртгэсэн ЭМ-той холбоотой капиталжуулсан зардлууд нь 2023 оны 12 сарын 31-ний байдлаар \$7,452,691 байсан нь 2022 оны мөн үеийн \$11,770,631-тай харьцуулахад буурсан үзүүлэлттэй байв. Энэ нь өнгөрсөн онд өрөмдлөгийн ажлууд багасч, Баянхөндий алтны төслийн бэлтгэл ажлын хүрээнд инженер болон зураг төслийн ажлын зардал багассантай холбоотой.
 - Компанийн ерөнхий ба захиргааны зардал нь 2023 оны 12 сарын 31-ны байдлаар \$3,137,736 байсан нь 2022 оны мөн үеийн \$2,218,984 -тай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байв. Энэ нь ММС-тэй байгуулсан стратегийн түншлэлийн хүрээнд удирдах баг тэлсэн, инфляцтай уялдсан цалингийн нэмэгдэл, маркетинг, мэргэжлийн зөвлөгөө, бэлэн бус хувьцаанд суурилсан урамшуулал, томилолтын зардлууд нэмэгдсэнтэй холбоотой.
 - 2023 оны 1 сард ММС-тэй байгуулсан Стратегийн түншлэлтэй холбоотойгоор Эрдэнэ Ресурсийн нягтлан бодох бүртгэлд өөрчлөлт орсноор ЭМ-д оруулсан хөрөнгө оруулсан дүнг өмчийн бүртгэлийн дагуу бүртгэн \$2,278,370 хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын алдагдал, хяналт алдагдсаны \$6,544,863 бэлэн бус орлого бүртгэсэн.

Стратеги, хэтийн төлөв

Эрдэнэ Ресурс нь Хөндий Эрдсийн Дүүрэг дэх үнэт болон суурь металлын ордуудыг нээн илрүүлэх, хөгжүүлэхэд чиглэн ажиллаж байна. Эрдэнэ Ресурсийн стратегийн зорилтуудад Баянхөндий алтны төслийг олборлолтын шат руу ахиулах болон хайгуул, хөрөнгө оруулалтэд тулгуурлан Хөндий Эрдсийн Дүүрэг дэх ордуудыг тэлэн, хөгжүүлэхэд оршино.

2023 оны 1 сард Хөндий Эрдсийн Дүүргийг хөгжүүлэхээр ММС-тэй байгуулсан стратегийн түншлэлийн гэрээ 2024 оны 1 сард эцэслэгдсэн. ММС нь Монголын нүүрсний салбарт баяжуулсан коксжих нүүрс олборлон, экспортлогч, хувийн хэвшлийн хамгийн том төлөөлөл. ММС нь Монгол Улсын Өмнөговь аймагт байрлах Ухаа худаг (“УХ”), Баруун наран (“БН”) коксжих нүүрсний уурхайд тус тус үйл ажиллагаа явуулдаг. Тус компанийн хувьцаа Хонконгийн хөрөнгийн биржид (HKEx:975) нээлттэй арилжаалагддаг бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ одоогоор ойролцоогоор 1 тэрбум ам.доллар байна.

ММС-ийн гол хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын тэргүүлэгч групп компаниудын нэг болох М-Си-Эс Групп юм. М-Си-Эс нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монгол Улсад инженерчлэл, барилга, эрчим хүч, харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, эрүүл мэнд, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж ирсэн бөгөөд нийт 10,000 гаруй ажилтантай, Монгол Улсын хамгийн том татвар төлөгчдийн нэг.

Эрдэнэ Ресурсийн геологи хайгуул, бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын чадвар, ММС-ийн олборлолт болон үйл ажиллагааны туршлага, М-Си-Эс групп компаниудын инженерчлэл, дэд бүтэц, эрчим хүчний шийдлүүдийг хангах боломжуудыг нэгтгэн, Хөндий Эрдсийн Дүүргийг хөгжүүлж, бүх оролцогч талуудад өгөөжийг бий болгох боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Баянхөндий алтны төслийн бүтээн байгуулалтыг амжилттай гүйцэтгэж байгаа ба 2023 оны хоёрдугаар хагаст боловсруулах үйлдвэрийн бутлуур, бетон зуурмагийн үйлдвэр, түлшний агуулах, түр кемп, барилгын зам, талбайн тэгшилгээ, нарийвчилсан газар шорооны ажлууд, томоохон төмөр бетон суурь, баганын суурилуулалт зэрэг байгууламжуудыг барьсан. Компани нь бүтээн байгуулалтын албан ёсны шийдвэрийг 2024 оны эхээр гаргасан. Мөн төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын (“ЕРС”) үйлчилгээний гэрээг MCS Property (“MCSP”), эрчим хүч худалдан авах гэрээ (“PPA”)–г MCS international (“MCSI”) буюу ММС-ийн харилцан хамаарал бүхий компанитай хийсэн. Бүтээн байгуулалтын хүрээнд төслийн талбайд 300 орчим ажилтан ажиллаж

байна. Бүтээн байгуулалт 2024 оны эцэст дуусаж, 2025 оны 1-р улиралд улсын комисст хүлээлгэж өгөхөөр төлөвлөж байна. Төслийн хуваарийн дагуу 2025 оны дундуур анхны бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөсөн.

Өнөөг хүртэл гүйцэтгэсэн хайгуулын үр дүнд илрүүлсэн Баянхөндий орд, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай, Улаан талбайг багтаасан Хөндий-Улаан томоохон хувирлын бүс нь алт агуулсан гидротермаль системийн нэг хэсэг бөгөөд олон сая унцын нөөц бүхий ордуудыг агуулах боломжтойг харуулж байна. 2023 оны алтны хайгуулын хөтөлбөрийн эхний үе шат нь Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд төвлөрөн ирээдүйд өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлэх бүсүүдийг тодорхойлсон.

2023 онд Эрдэнэ Ресурс нь Ази тивийн хамгийн том хөгжүүлэлт хийгдээгүй молибден-зэсийн ордуудын нэг Зуун Мод төслийг хөгжүүлэхээр 4100 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлж дууссан. Хайгуулын хөтөлбөрөөс гадна Эрдэнэ Ресурс нь 2021 оны сүүлээр RPMGlobal (Minarco-Mine Consult)-аас хийсэн урьдчилсан үнэлгээ дээр тулгуурлан ирэх саруудад зах зээл, техник, эдийн засгийн судалгаа, тусгай зөвшөөрөл авах ажлуудыг гүйцэтгэнэ. Тусгай зөвшөөрлийн талбайд Зуун Мод төслөөс гадна хэд хэдэн зэс ба молибденийн хэтийн төлөв бүхий талбай багтдаг. Зуун Мод порфирийн цогцолборын хойд хэсэгт байрлах Хөвийн Хар талбай нь филлийн ба калийн хувирлын кварц монзонит ба гранодиоритын интрузив бүхий хэдэн км зайд тархсан зэсийн хүдэржилт бүхий томоохон талбайг хамардаг. Өргөн зайтай өрөмдсөн өрөмдлөгөөр зэсийн хэд хэдэн хүдэржсэн бүсүүдийг огтолсон ба ZMD-121 цооногт 308-аас 342 метрт 1.3% зэс, 9.24 г/т мөнгөний агуулга бүхий 34 метрийн интервал огтолсон. Зуун Мод порфирийн томоохон цогцолборт хязгаарлагдмал судалгаа хийсэн удирдлагууд тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийг нэмэгдүүлэх хэтийн төлөв бүхий хэд хэдэн талбай байгаа хэмээн тодорхойлсон.

Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, хэтийн төлөв бүхий 20 гаруй талбайг тодорхойлсон. Энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна. Монголиан Майнинг Корпорэйшн-тэй хийсэн стратегийн түншлэлийн хүрээнд Эрдэнэ Ресурс нь Хөндий Эрдсийн Дүүргийн хүрээнд тендер болон тусгай зөвшөөрөл эзэмших боломжуудыг судлан, оролцоно. Нэмэлтээр, компани нь өнгөрсөн хугацааны хайгуулын туршлагад тулгуурлан үнэт болон суурь металлын нөөц бүхий боломжит бүс нутгуудыг тодорхойлохоор ажиллана.


Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд

NI 43-101 Техникийн тайлангууд– Геологийн ба үйлдвэрлэлийн нөөц

2018 оны 9 сарын 15-нд Компани нь Хөндий алтны төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг танилцуулсан. Компани нь NI 43-101 ("NI 43-101")-д заасан "Ашигт малтмалын төслийн ил тод байдлын стандарт"-д заасан стандартын дагуу техникийн тайланг бэлтгэдэг. 2023 оны 9 сарын 25-ны өдөр Монгол болон олон улсад үйл ажиллагаа эрхэлдэг, туршлагатай мэргэжлийн зөвлөх байгууллагууд хамтран боловсруулсан. Техникийн тайланг O2 Mining Ltd болон Roma Group Ltd-ийн удирдлагын дагуу Эрдсийн нөөцийн тайлагналын NI 43-101 стандартаар ("NI 43-101") боловсруулж 2023 оны 8 сарын 15-ны өдөр танилцуулсан.

Алтан Нар, Хар Морь болон Зуун Модын ордоос бусад Компанийн эзэмшлийн хайгуулын талбай нь хайгуулын эхний шатанд явж буй бөгөөд NI 43-101 тайлагналын стандартын дагуу тайлагнах нөөцийн тайланг боловсруулаагүй. Дээр дурдсан ордуудаас гадна энэхүү Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээнд дурдсан талбайн боломжит агуулга болон хэмжээ нь урьдчилан таамагласан таамаглал бөгөөд нөөцийн тайланг боловсруулах хэмжээний хайгуулын судалгаа хийгдээгүй болно. Компанийн төслүүдийн тухай нэмэлт мэдээллийг www.sedarplus.ca, SEDAR+ дахь компанийн хуудаснаас NI 43-101 техникийн тайлан, жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлүүдээс ("AIF") авч танилцах боломжтой.

Хөндий Эрдсийн Дүүрэг



Хөндий Эрдсийн Дүүрэг нь компанийн газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий Баянхөндий, Хар Морь ба Алтан Нар орд, Зүүн Өмнөд Улаан, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай болон Зуун Мод молибден-зэсийн ордоос бүрддэг.

Баянхөндий ("Rich Valley") алтны орд нь 2309 га Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийг Эрдэнэ Ресурсийн охин компани Эрдэнэ Монгол ХХК эзэмшдэг. Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөлд Баянхөндий, Хар Морь төслүүд багтдаг ба нөөцийг "Bayan Khundii Gold Project, Feasibility Study Update, NI 43-101 Technical Report"-д тусгасан болно.

Баянхөндий алтны төсөл

2023 оны 8-р сарын 15-нд Эрдэнэ Ресурс нь Баянхөндий алтны төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн эерэг үр дүнг танилцуулсан. Энэхүү хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2023 оны 9 сарын 25-нд NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу "Bayan Khundii Gold Project Feasibility Study Update, NI 43-101 Technical Report" нэртэйгээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай олон улсын ба Монголын мэргэжлийн зөвлөх байгууллагууд хамтран боловсруулав. Тайланд: нарийвчилсан уурхайн загварчлал, уулын ажлын хуваарь, боловсруулах үйлдвэрийн анхан шатны инженерийн загварчлал ("FEED"), уурхайн дэд бүтэц, гидрогеологийн үнэлгээ, эрдсийн хаягдлын нэгдсэн байгууламжийн загварчлал, хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны дэлгэрэнгүй зардал, тооцоолол болон эдийн засгийн шинэчилсэн загварчлалыг танилцуулсан.

Нарийвчилсан ТЭЗҮ-д газрын дөт гүн дэх өндөр агуулга бүхий Баянхөндий ордыг ил аргаар олборлохдоо ордын өмнөд хэсгээс хойш (Страйкер болон Алтан Толгой), залгаа орших Мидфийлд болон Зүүн-Хойд Мидфийлд бүсүүдийг үргэлжлүүлэн хойд зүгт чиглэн олборлохоор төлөвлөсөн. Хөгжүүлэлтийн төлөвлөгөө нь уламжлалт нүүрсэнд уусгах технологиор ("CIP") өдөрт дунджаар 1950 тонн хүдэр боловсруулах үйлдвэрт суурилсан. 2023 оны нарийвчилсан ТЭЗҮ-д Баянхөндий төслийн 4.0 г/т алтны агуулга бүхий 4.0 сая тонн хүдэр багтсан бөгөөд эдгээр нь бүгд батлагдсан ба магадалсан үйлдвэрлэлийн нөөц (Proven and Probable Reserves) юм. Баянхөндийн нарийвчилсан ТЭЗҮ-д тусгагдсанаар, жилд 650,000 тонн хүдрээр үйлдвэрийг тэжээх хүчин чадал бүхий ил уурхайг төлөвлөж байна. Олборлох боломжтой хэмжээг 4.0 сая тонн, үүнд 4.0 г/т дундаж агуулга бүхий хүдэр багтсан бөгөөд хөрс хуулалтын харьцаа 10.9:1 байна (тонн хаягдал: тонн үйлдвэр тэжээх хүдэр). Хүдэржилт нь газрын дөт гүнд буюу хүдрийн дийлэнх хэсэг нь газрын гадаргаас доош 100 метрийн гүнд байна. Ордын бүтэц, агуулга болон гүнээс шалтгаалан ил уурхайн аргаар ашиглах боломжтой. Одоогийн төлөвлөж буй ил уурхайгаас доош далд уурхайн ашиглалт нь ТЭЗҮ-д багтаагүй бөгөөд ирээдүйд судалгаа хийгдэх боломжтой. Ашиглалтын үед урвуу хутгуурт гидравлик экскаватор ашиглана. Тэсэлсэн хөрс, материалыг автосамосвалд ачин, хаягдал материалыг уурхайтай залгаа орших хаягдлын нэгдсэн овоолгод хуримтлуулан, хүдрийг боловсруулах үйлдвэрийн дэргэдэх тээрэм рүү шилжүүлнэ.

2023 онд шинэчилсэн ТЭЗҮ дэх Баянхөндий төслийн геологийн нөөцийн тооцооллыг (“Mineral Resource”) AGP Mining Consultants Inc. (“AGP”) NI 43-101 болон CIM стандартын дагуу боловсруулсан бөгөөд 2023 оны 4 дугаар сарын 20-нд батлагдсан. Баянхөндий төслийн геологийн нөөцийг NI 43-101-т тодорхойлсон мэргэшсэн этгээд болох Paul Daigle, P. Geo боловсруулсан.

Геологийн нөөцийг төлөвлөж буй ил уурхайн ханаар хязгаарлан, хэд хэдэн захын агуулгад тулгуурлан тооцоолсон боловч 0.40 г/т захын агуулгыг ашигласан. Захын агуулгын тооцооллууд болон төсөөллүүдийг Доорх хүснэгт ба тэмдэглэлүүдэд танилцуулсан.

Баянхөндий алтны төсөл – Геологийн нөөцийн тооцооллын хураангуй, 2023 оны 4-р сар

Ангилал	Хэмжээ (сая.т)	Алтны агуулга (Au г/т)	Унц алт (мян.унц)	Мөнгөний агуулга (Ag г/т)	Унц мөнгө (мян.унц)
Баттай	4.0	3.03	394	1.44	187
Бодитой	3.3	2.04	219	1.22	131
Баттай ба Бодитой	7.4	2.58	613	1.34	319
Боломжтой	0.2	1.08	6	1.32	8

Тэмдэглэл:

1. Геологийн нөөц нь эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй.
2. Бүхэлдсэн дун нь нийлбэр дүнд нөлөөлж болзошгүй.
3. Геологийн нөөцийн батлагдсан огноо: 2023 оны 4 сарын 20
4. Ил уурхайн геологийн нөөц нь уурхайн ханын хязгаарын оновчлолд багтсан.
5. Дараах үзүүлэлтэд тулгуурлан ил уурхайн захын алтны агуулгыг 0.4 г/т тооцсон:
 - Алтны үнийг нэг унц нь US\$2,000-аар тооцоолов.
 - Алт авалт 95%
 - Олборлолтын зардал нэг тонн тутамд \$3.00
 - Олборлолтын зардал болон ерөнхий, захиргааны зардал нэг тонн тутамд \$22.00
 - Нэгдмэл утгад 1м-т алтны агуулгыг 200 г/т, мөнгөний агуулгыг 50 г/т-оор хязгаарласан.
 - Нягтаршил нь литологиос хамааран 2.58 г/см³ - 2.66 г/см³ хооронд хэлбэлзэнэ.

Хар Морин Дэл ордын геологийн нөөцийн тооцоолол

2023 онд шинэчилсэн ТЭЗҮ-д Компани нь Баянхөндий алтны ордоос хойд зүгт 2 км-ийн зайд орших Хар Морин Дэл алтны орд (“Dark Horse Mineral Resource”)–ын анхан шатны геологийн нөөцийн тооцооллын тоймыг танилцуулж буйдаа таатай байна. Хар Морин геологийн нөөцийн тооцооллыг (“Mineral Resource”) RPM Global (“RPM”) NI 43-101 болон CIM стандартын дагуу боловсруулсан бөгөөд 2022 оны 11 дугаар сарын 02-нд батлагдсан.

Хар Морин геологийн нөөцийн захын агуулгыг тооцохдоо исэлдсэн болон шилжилтийн хүдрийн хүрээнд 0.35 г/т алтны агуулга, анхдагч хүдрийн хүрээнд 1.02 г/т байхаар тооцоолсон. Геологийн нөөцийг төлөвлөж буй ил уурхайн ханаар хязгаарласан. Захын агуулгын тооцооллууд болон төсөөллүүдийг доорх хүснэгт ба тэмдэглэлүүдэд танилцуулав.

Хар Морь алтны орд – Геологийн нөөцийн тооцооллын хураангуй, 2022 оны 11-р сард

Төрөл	Бодит геологийн нөөц			Боломжит геологийн нөөц		
	Тонн (мян.т)	Агуулга г/т Au	Унц (мян унц)	Тонн (мян.т)	Агуулга г/т Au	Унц (мян.унц)
Исэлдсэн	578	3.0	56.2	75	1.1	2.7
Шилжилтийн	99	1.5	4.8	109	1.2	4.1
Анхдагч	5	4.9	0.7	-	-	-
Нийт	682	2.8	61.7	184	1.2	6.8

Тэмдэглэл:

1. Геологийн нөөцийн тооцооллыг Австралийн газар зүйн шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн, RPM Global компанийн ажилтан Бат-Очирын Оюунбат (“Oyunchat Bat-Ochir”) боловсруулж баталгаажуулсан. Оюунбат нь ордын эрдэсжилт болон ордын хэв маяг, хэлбэрийн талаар хангалттай туршлагаатайгаас гадна CIM-ийн ил тод байдлын стандартад тодорхойлсон Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
2. Дээрх хүснэгтэд тайлагнасан бүх нөөцийн тооцооллууд нь 2022 оны 11-р сарын 1-ны өдрийн тооцоолол юм. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээрх өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурласан бүхэл тоогоор тоймлогсон болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай.
3. Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
4. Геологийн нөөцийн захын агуулгыг исэлдсэн болон шилжилтийн хүдрийн хувьд 0.35 г/т, анхдагч хүдрийн хүрээнд 1.02 г/т байхаар тооцоолсон. Эдгээр захын агуулгын тооцоог RPM-ийн дотоод захын агуулгын тооцоолуураар тодорхойлсон бөгөөд үүнд хүдрийн 5%-ийн алдагдал 10%-ийн бохирдол ба алтны үнийг нэг унц нь US\$1,723 байхаар

тооцоолсон. Мөн олборлолтын зардал нэг тонн тутамд US\$3, нэг тонн хүдрийг боловсруулах зардал US\$16, тээрэм болон боловсруулалтын хувь хэмжээ нь исэлдсэн хүдрийн хувьд 90%, шилжилтийн хүдрийн хувьд 87%, анхдагч хүдрийн хувьд 30% байх төсөөлөлд тулгуурлан боловсруулсан. Нөөцийн тайланд уурхайн оновчилсон хязгаарыг алтны үнэ \$2,000 ам.доллараар төсөөлсөн нь урт хугацааны урьдчилан таамагласан үнээс 1.4 дахин өндөр байна.

- Дээрх геологийн нөөц нь эдийн засгийн тооцоололд ороогүй бөгөөд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэхийг тооцоогүй болно.

Баянхөндий болон Хар Морь ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоолол

Баянхөндий болон Хар Морь ордын ТЭЗҮ-д багтсан үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллыг O2 Mining Limited-ийн захирал, мэргэшсэн этгээд Жулиен Лауренс NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартад (“NI 43-101”) нийцүүлэн боловсруулсан. Баянхөндий ордын нийт үйлдвэрлэлийн нөөц, Хар Морин Дэл ордын үйлдвэрлэлийн нөөц тус бүрийг дор харуулав. Үйлдвэрлэлийн нөөц (“Mineral Reserve”) нь энэхүү УХДШ-д тусгасан шинэчилсэн геологийн нөөц (“Mineral Resource”)–д үндэслэсэн. Баянхөндий болон Хар Морийн үйлдвэрлэлийн нөөц нь баттай болон бодит (“Measured and Indicated”) геологийн нөөцөд үндэслэсэн ба 2023 оны 8 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Нөөцийг боловсруулахдаа O2 Mining компани нь ТЭЗҮ-ийн түвшний ил уурхайн инженерийн загварчлал болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны үзүүлэлт дээр тулгуурласан.

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоололд захын агуулгыг нэг унц алтны ханш \$1,816 байхад тулгуурлан, Баянхөндий ордын хувьд 0.63 г/т алт, Хар Морь ордын хувьд 0.68 г/т алтны агуулгаар тооцоолсон. Уурхайн блок загварт тодорхойлсноор эрдсийн алдагдал 2.5%, бохирдол 10% байна.

Доор танилцуулсан Баянхөндий болон Хар Морь ордын үйлдвэрлэлийн нөөцийн тайлан 2023 оны 08-р сарын 01-ний өдрөөр хүчин төгөлдөр болсон.

Баянхөндий алтны орд – Үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллын хураангуй

Ангилал	Тонн (мян.т)	Агуулга (г/т Au)	Агуулсан Au (мян.унц)	Агуулга (г/т Ag)	Агуулсан Ag (мян.унц)
Батлагдсан	2.7	4.1	360.2	1.8	159.4
Магадалсан	1.1	3.0	104.7	1.7	61.1
Нийт	3.8	3.8	464.9	1.8	220.5

Хар Морь алтны орд – Үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллын хураангуй

Ангилал	Тонн (мян.т)	Агуулга (г/т Au)	Агуулсан Au (мян.унц)
Батлагдсан	-	-	-
Магадалсан	0.2	7.0	48.8
Нийт	0.2	7.0	48.8

Тэмдэглэл:

- Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо 2023 оны 8 сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон бөгөөд O2 Mining Limited компанийн Жулиен Лауренс нь мэргэшсэн этгээд;
- Ашигт малтмалын нөөцийн тооцооллыг 2014 оны Канадын Уул уурхай, Металлург болон Газрын тосны хүрээлэнгийн (CIM) Тодорхойлолтын Стандарт (2014 CIM Тодорхойлолтын Стандарт) болон 2003 оны CIM Шилдэг Практик Удирдамжийн дагуу бэлтгэсэн;
- Нөөцийг ил уурхайн аргаар олборлохоор тооцоолсон;
- Хаягдал болон хүдрийн захын хязгаарыг моделийн блок бүрийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрт тулгуурлан тооцсон. БЦАТ-ийг уурхайн бус алдагдал, тээвэрлэлт, хайлуулах болон цэвэршүүлэх зардлуудад тулгуурлан тооцоолсон;
- Нөөцийг тооцоолохдоо нэг унц алтны үнэ \$1,816 ам.доллар төсөөлөл дээр үндэслэсэн;
- Үйлдвэрлэлийн нөөцийг хорогдуулсан олборлолтын блок моделд суурилж боловсруулсан бөгөөд 10%-ын хорогдол болон 2.5%-ын алдагдалтай байхаар тооцсон.

2023 оны ТЭЗҮ-д овоолгын хүдрийн материалыг боловсруулахдаа уламжлалт буюу бутлан, тээрэмдэж, баяжуулан, нүүрстэй уусгах технологиор алтыг ялгаж авахаар төлөвлөсөн. 360Global нь боловсруулах үйлдвэрийн загварчлалыг Blue Coast Research-ийн боловсруулалтын үзүүлэлтийн оновчлол зэрэг судалгаанд тулгуурлан тодорхойлсон. Энэхүү оновчлолд 60 микронд хүргэн 80% хүртэл бутлах, нунтаглах мөчлөгийн өгөгдлийн загварчлал, баяжуулах мөчлөгийн бага цианидийн баяжуулалт (0.5 г/л натрийн цианид); 36 цагийн хадгалалт, нүүрсэнд шингээх үзүүлэлтүүд, хоргүйжүүлэх урвалжийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүд багтсан. Боловсруулах мөчлөг нь усны нөхөн сэргээлтийг хамгийн өндөр түвшинд байлгах, усгүйжүүлэх үйл явцыг хамгийн үр дүнтэй буюу

хаягдлын чийгшлийг 15%-д байлгах, химийн болон урвалжийн хэмжээг бууруулж, байгаль орчны нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахаар төлөвлөсөн.

Хүдэр боловсруулах үйлдвэрийг Баянхөндийн ил уурхайтай зэрэгцээ барих бөгөөд өдөрт 1,935 тонн хүдэр, жилд 650,000 тонн хүдэр боловсруулна. Уурхайн ашиглалтын хугацаанд 4.0 г/т дундаж агуулга бүхий нийт 4.0 сая тонн хүдрийг боловсруулна. Төслийн хугацаанд металл авалт 92.6% байх бөгөөд Баянхөндий ордоос нийт 476,001 унц алт үйлдвэрлэнэ.

Үйл ажиллагааны зардлыг дээр дурдсан олборлолтын болон боловсруулалтын хувилбарууд дээр үндэслэн, эзэмшигч олборлолтыг гүйцэтгэхээр төсөөлсөн. Үйл ажиллагааны хүрээнд уурхайн эрчим хүчийг дизель болон нарны эрчим хүч хослуулсан эрчим хүч худалдан авах гэрээний дагуу хангана. Бусад зардлуудыг компани хариуцан ажиллана. Баянхөндий төслийн хувьд нэг унц алт үйлдвэрлэх нийт нэгжийн өртөг \$869 ам.доллар байхаар тооцоолсон.

Үйл ажиллагааны зардал

	УАХ (сая ам.дол)	Ам.дол/унц	Ам.дол/тонн
Олборлолтын зардал	165	347	41
Боловсруулалтын зардал	166	349	41
Ерөнхий ба захиргааны зардал	20	43	5
Нийт үйл ажиллагааны зардал	352	739	88
Нөөц ашигласны төлбөр & бусад зардал	51	108	13
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт ба уурхайн хаалтын зардал	10	22	3
Алт үйлдвэрлэх нэгжийн өртөг	414	869	103

Тэмдэглэл: Бүхэл тоогоор тоймолсон дүн нь тооцооллын зөрүү үүсгэх боломжтой

Хөрөнгийн зардал

Уурхай байгуулалт, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны хөрөнгийн зардлыг 88 сая ам.доллар хэмээн тооцоолсон. Боловсруулалтын өмнөх зардал, эхний дүүргэлт, талбайн хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн зардал нь 2 сая ам.доллар болохоор тооцоолсон. Үүнд нэмэлтээр хөрөнгийн зардлын тооцоонд 12% буюу 10 сая ам.долларын болзошгүй зардлыг шингээсэн. Тогтвортой хөрөнгө оруулалтад 4 сая ам.доллар, үлдэгдэл өртгийг багтаасан хаалтын зардалд 5 сая ам.долларыг тусгасан. Баянхөндий алтны төслийн ашиглалтын хугацааны нийт хөрөнгийн зардлыг 109 сая ам.доллар хэмээн тооцов. Өнөөдрийг хүртэл ойролцоогоор 8 сая долларын зардал гарсан бөгөөд энэ нь урт хугацаанд ашиглах тоног төхөөрөмж, түр барилга байгууламж, газар шорооны ажил зэрэгт урьдчилгаа байдлаар зарцуулсан.

	сая ам.дол
Боловсруулах үйлдвэр	47
Үйлдвэрээс бусад дэд бүтэц	14
Барилга байгууламжийн шууд бус зардал	27
Бүтээн байгуулалтын зардал	88
Олборлолтын өмнөх зардал	2
Болзошгүй зардал	10
Нийт боловсруулах үйлдвэр ба дэд бүтэц	100
Тогтвортой хөрөнгө оруулалт	4
Нөхөн сэргээлт ба уурхайн хаалт	7
Үлдэгдэл өртөг	(2)
Нийт	109

Тэмдэглэл: Бүхэл тоогоор тоймолсон дүн нь тооцооллын зөрүү үүсгэх боломжтой

Дүүргийн хэмжээний хайгуул

Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 20 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий Эрдсийн Дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг багтаахаас гадна Баянхөндий төслийг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна.

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай болон Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий-Улаан гидротермаль хувирлын бүсийг агуулан, 4000 гаруй га талбайг хамран оршдог бөгөөд хувирлын бүс нь Улаан талбайгаас зүүн хойш чиглэн 10 км үргэлжилдэг. Энэхүү хувирлын тренд нь Баянхөндий алтны ордыг агуулагч цагаан гялтгануур, серицитийн гадна бүс болон серицитийн хувирлын захаар хүрээлүүлсэн хүчтэй хоёрдогч цахиурын төв бүсийг агуулдаг. Энэхүү зүүн өмнөд трендийн дагуу хувирсан бүсэд Улаан, Баянхөндий болон Хар Морь зэрэг бусад эрдэсжсэн хэтийн төлөв бүхий талбай багтаж байгаа нь зүүн өмнөд трендийн хагарлын дагуу бүс нутгийн структурын тэлэлтийн тэгш бус байдал ба томоохон галт уул - плутоник төвтэй холбогддог. Хөндий-Улаан талбай дахь хэтийн төлөв бүхий болон зэргэлдээ орших бүсүүдийн хүдэржилт, хувирлууд нь томоохон структурын дагуу давхцаж эсвэл сунаж эрдэсжсэн нуман шилжилт бүхий баялаг магмын арлын нуман хувиралтай уялддаг.

Өнөөдрийг хүртэл хийсэн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүнгээс харахад Хөндий-Улаан хувирлын систем болон алтны илрэлүүд илэрсэн энэхүү том алт агуулагч гидротермаль систем нь бүрэн судлагдаагүй хэвээр байна. Өнөөг хүртэл тогтоогдсон алтны хүдэржилт нь Хөндий-Улаан гидротермаль хувирлын системийн хязгаарын дагуу тэлсэн цагаан гялтгануур ба цахиураар хувирсан туйлын үед байрлаж байна. Кварцын судал, шаврын хувирлын бүтцээс харахад Хөндий-Улаан системд томоохон эпитеpmаль хэв шинжийн алтны хүдэржилтийг агуулж, туйлын литологи нь алтны хүдэржилтийг бүрдүүлэх таатай орчныг бий болгож ээ. Одоогоор Хөндий-Улаан талбайд хэд хэдэн геологи, геохими болон геофизикийн бүсүүдийг шалгах хайгуулын төлөвлөгөөг боловсруулж байна.

Бүс нутгийн өрөмдлөгийн хөтөлбөрийн дундаж гүнийг 100 метр орчим гүехэн өрөмдлөгөөр хязгаарласан бөгөөд цооногуудын 70 орчим хувь нь аномаль алтны хүдэржилт (>0.1 г/т алт) огтолсон. Өмнө нь орчин үеийн хайгуул хийгээгүй бүс нутагт газрын дөт гүнд геохими, геофизикийн хэтийн төлөв бүхий талбайнуудыг тодорхойлсон нь амжилтад хүрэх хүчин зүйл байв. Газрын дөт гүн хэтийн төлөв бүхий талбайг судалж, газрын гадаргад ойр гурван ордыг тодорхойлсон хайгуулын амжилт нь энэхүү шинэ дүүргийн нээлтийг баталж байна.

Хар Морь хэтийн төлөв бүхий талбай

Хар Морь хэтийн төлөв бүхий талбай нь Баянхөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн хойд хэсэгт оршдог бөгөөд 1 г/т алтны агуулгаас өндөр чөмгөн дээж, суваг малталт болон гадаргын чулуулгийн дээжлэлт бүхий хөрсний аномализм дахь алтны утгаар тодорхойлогддог (~20 км²). Хар Морь бүсийн газрын дөт гүн дэх алтны хүдэржилт нь структурын хяналттай хувирал болон өргөн бүсийг хамран палеон гадарга руу ойртон алт агуулагч шингэнийг тараан, тэжээгч структуртай холбогдож байна хэмээн үздэг. Компани нь Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших Хар Морь талбайд одоогийн байдлаар нийт босоо тэнхлэгийн дагуу 8-с 318 метрийн 236 цооногийн 25,132 тууш метрийн өрөмдлөг хийсэн, үүний 1,040 тууш метрийн 18 цооногийн өрөмдлөг нь 2023 онд хийгдсэн.

Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөр нь 2021 оны эхээр нээн илрүүлсэн Хар Морин Дэл бүсэд төвлөрсөн. Эрдэнэ Ресурс нь Баянхөндий ордоос хойд зүгт 2.4 км-т өрөмдлөгийн хөтөлбөр гүйцэтгэснээр Хар Морин Дэл бүсийг илрүүлсэн. Энэхүү өрөмдлөгөөр (AAD-58) цооногийн 10 метрээс 27.1 г/т алтны агуулга бүхий 8 метр агуулсан 5.97 г/т алтны агуулга бүхий 45 метрийн интервал огтолсон. Өнгөрсөн жилийн өрөмдлөгийн үр дүнд Хар Морин Дэл талбайд 1.5 км-ийн хувирлын тренд, алтны хүдэржилтийг тодорхойлсон бөгөөд хойд, өмнө болон гүндээ судлын дагуу нээлттэй. Анхны нээлтээс хойш Хар Морин Дэл бүсэлд хийсэн ажлуудын онцлох үр дүн:

- AAD-126: Цооногийн 10 метрээс эхлэн 5.63 г/т алтны агуулга бүхий 30 метрийн интервал огтолсон бөгөөд түүнд цооногийн 26 метрээс эхэлсэн 24.12 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал багтаж байна
- AAD-137: Цооногийн 1.5 метрээс эхлэн 9.4 г/т алтны агуулга бүхий 24.5 метр огтолсонд 16.1 г/т алтны агуулга бүхий 13.5 метрийн интервал багтсан
- AAD-138: Цооногийн 18 метрээс эхлэн 6.1 г/т алтны агуулга бүхий 25 метр огтолсонд 17.1 г/т алтны агуулга бүхий 8 метрийн интервал багтсан
- AAD-177: Цооногийн 1 метрээс эхлэн 11.4 г/т алтны дундаж агуулга бүхий 23 метр огтолсонд 32.2 г/т алтны агуулга бүхий 8 метрт 59.8 г/т алтны агуулга бүхий 4 метрийн интервал багтаж байна
- AAD-178: Цооногийн 11 метрээс эхлэн 42.8 г/т алтны дундаж агуулга бүхий 15 метр огтолсонд 123.5 г/т алтны агуулга бүхий 5 метрт 160.4 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал багтаж байна
- AAD-218: Газрын гадаргаас эхлэн 20.2 г/т алтны агуулга бүхий 12 метр огтолсонд 39.6 г/т алтны агуулга бүхий 6 метрийн интервал багтсан

Хар Морин Дэл бүс нь анхдагч эрдэсжүүлэгч шингэнийг дамжуулагч хэмээн тайлбарладаг зүүн хойд трендийн дагуу гүнд байрлах хувирлын хагарлыг огтолж буй хойд-өмнөд тренд, шугаман структурын коридортой холбогддог. Хойд-Өмнөд структур нь Баянхөндийн өмнөд хэсгээс Хар Морийн хойд тэлэлтийн бүс хүртэл 5 км талбайг хамардаг. Алтны хүдэржилт нь кварц, кварц-гематит судал болон штокверк бүсээр огтолсон хүчтэй хувирсан туф болон галт уулын чулуулгийн дотор оршиж байна. Хар Морин Дэлийн дөт гүн дэх исэлдсэн бүс нь газрын гадаргаас эхлэн, 1 метрээс дээш 195 г/т алтны агуулга бүхий супергенээр баяжуулсан алтны бүсүүдийг агуулан, хугарлын дагуу хэсэгчлэн гүн исэлдэн 20-60 метрийн босоо гүнд өөр өөр зузаантай оршиж байна. Өндөр агуулга бүхий исэлдсэн биет нь хойд өмнөд суналын дагуу үргэлжилж байгааг тодорхойлсон. Хүдэржилт нь судлын дагуу болон гүндээ нээлттэй ч газрын дөт гүнд ойр хүдэржилтийн хэсэг нь Баянхөндий төслийн нэг хэсэг болох Хар Морин Дэлийн нөөцийг бүрдүүлдэг.

Хар Морин Дэл бүс дэх газрын дөт гүний исэлдсэн алтны бүс нь цагаан гялтгануураар хувирсан литологи агуулагч гидротермаль брекч ба сульфид агуулсан эпитеpmаль судлын исэлдлийн үр дүн юм. Өрөмдлөгийн хязгаарлагдмал гүний судалгаагаар алт агуулагч эпитеpmаль судал түүнтэй холбоотой цагаан гялтгануур сульфид хувирлын бүсүүд нь босоо гүнд 230 метр хүртэл ажиглагдсан бөгөөд гүндээ нээлттэй. Хар Морин Дэл бүсийн газрын дөт гүн дэх алтны хүдэржилт нь структурын хяналттай хувирал болон өргөн бүсийг хамран палеон гадарга руу ойртон алт агуулагч шингэнийг тараан, тэжээгч структуртай холбогдож байна хэмээн үздэг. Эдгээр тэжээгч структур нь гүндээ зэсийн аномаль нэмэгдэж буй алтны хүдэржилтээс өмнөх үетэй холбогдон, хэд хэдэн ил гарсан үлдэгдэл кварцын литокапуудыг агуулдаг. Эдгээр литокапууд нь гүндээ магмын порфирийн эх үүсвэрээс тэжээгч бүсүүд болон хагарлын хувирлыг төлөөлж буй Хойд-Өмнөд трендийн структурын дагуу давамгайлсан тархсан. Дээр танилцуулсан өндөр агуулга бүхий алт агуулагч исэлдсэн бүсүүд нь кварц литокапийн үлдэгдэл болон туфаас порфирит галт уулын задралын нэгжид байрлаж байна.

2023 оны 2-р улиралд Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд хайгуулын өрөмдлөг болон цахилгаан туйлшралын судалгааг хийснээр хэд хэдэн шинэ бүсийг тодорхойлсон. Хөтөлбөрийн үед газрын дөт гүнд хэд хэдэн алт болон индикатор элементийн аномаль тодорхойлсон ба үүний 10 цооногт аномаль алт (0.1 г/т-с дээш алтны агуулга бүхий), 6 цооногт индикатор элементийн хүдэржилт илэрсэн. Хар Морь ордын онцлог шинж чанар болох алт, сурьма, хүнцэл болон молибден нь Хар Морин Дэлийн газрын дөт гүнд, өндөр агуулгатай алтны хүдэржилтийг илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Зүүн Өмнөд Улаан

2021 оны 6-р сард Компани нь Баянхөндий ордоос баруун зүгт 300 метрт Улаан тусгай зөвшөөрлийн талбайд анхан шатны өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлснээр томоохон алтны шинэ нээлтийг илрүүлсэн. Өнөөг хүртэл гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүнд Зүүн-Өмнөд Улаан нэртэй томоохон алтны нээлт илрүүлсэн. Хэд хэдэн цооногуудад (354 метр хүртэл) алтны хүдэржилт илэрсэн бөгөөд 200-250 метрийн талбайг хамарсан энэхүү өрөмдлөгийн дийлэнх нь хүдэржилтээр төгссөн. Зүүн Өмнөд Улаан талбайд огтолсон алтны хүдэржилт нь газрын гадаргаас ойролцоогоор 80 метрийн гүнээс эхлэх бөгөөд талбайн зүүн талд орших Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл дэх Баянхөндий эпитеpmаль алтны ордыг агуулагч цагаан гялтгануурын хувиралтай лапилли туфтай ижил зузаалагт агуулагдаж байна. 156.5 г/т хүртэл алтны агуулга нь агуулагч структур болон тэжээгч бүсүүдтэй холбоотой кварцгематитын судлууд, штокверк бүсүүдэд тохиолдоно. Өмнөд Улааны алтны хүдэржилт дэх нэвчүүлэх чадвар багатай, цахиуржсан үнслэг туф бүхий литологи нь хүдэр агуулсан уусмалыг хэсэгчлэн хязгаарласнаар хүдэржихэд илүү тохиромжтой томовтор мөхлөгтэй лапил туфуудыг хүдэр агуулагч чулуу болгосон гэж үзэж байна. Структурын хяналт нь баруун хойд чиглэлтэй төстэй, баруун өмнөд чиглэлтэй унасан судлууд нь алт агуулж байгаа бөгөөд захын структур ба/эсвэл тэжээгч сувгууд нь ихэвчлэн зүүн хойд ба хойд зүгт чиглэсэн. Алтны хүдэржилт нь голлон бага агуулгатай, мөн литологиор хэсэгчлэн хянагдсан байх ба илүү томовтор мөхлөгтэй лапилли туф-д хүдэржилт голчлон төвлөрсөн нь баруун хойд зүг рүү давхарга зүйн уналаар нарийн ширхэгтэй цахиуржсан үнслэг туф нь хүдрийн уусмалыг нэвчүүлэх чадвар сул байдагтай холбоотой.

Анхны нээлтээс хойш Улаан тусгай зөвшөөрлийн зүүн өмнө талбайд хийсэн ажлуудын онцлох үр дүн:

- UDH-14 цооногийн 188 метрээс эхлэн 1.07 г/т алтны агуулга бүхий 217 метр интервал огтолсон нь 3.55 г/т алтны агуулга бүхий 53 метрийн интервал агуулсан
- UDH-21 цооногийн 115 метрээс эхлэн 3.19 г/т алтны агуулга бүхий 77 метр огтолсон нь 8.74 г/т алтны агуулга бүхий 27 метрийн интервал агуулж байна
- UDH-22 цооногийн 85 метрээс эхлэн 3.11 г/т алтны агуулга бүхий 65 метрийн интервал агуулсан 1.71 г/т алтны агуулга бүхий 152 метр огтолсон

- UDH-35: цооногийн 187 метрээс эхлэн 13.7 г/т алтны агуулга бүхий 23 метр багтаасан 8.1 г/т алтны агуулга бүхий 41 метрийн интервал огтолсон
- UDH-36 цооногийн 72 метрээс эхлэн 1.2 г/т алтны агуулга бүхий 179 метр интервал огтолсон. Үүнд 10-33 г/т алтны өндөр агуулга бүхий хэд хэдэн 1 метрийн интервалууд огтолж, 350 метрт хүдэржилтээр төгссөн
- UDH-53 цооногийн 248 метрээс 24.9 г/т алтны агуулга бүхий 2 метр багтаасан 3.47 г/т алтны агуулга бүхий 27 метрийн интервал огтолсон

Баянхөндий орд, Хар Морь хэтийн төлөв бүхий талбай, Зүүн-Өмнөд Улаан талбайд хийсэн өрөмдлөгийн үр дүн нь Улаан талбайгаас зүүн хойд зүгт Хөндий тусгай зөвшөөрөл хүртэл 10 гаруй км үргэлжилдэг 4000 га талбайг хамрах Хөндий-Улаан гидротермаль системийн хүдэржилтийн цар хүрээг харуулж байна.

Төв болон хойд Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь газрын гадарга дээр 5км х 4км хэмжээтэй филлик хувирлын (кварц-серицит-пирит) өргөн бүс үүсгэсэн порфирийн хэтийн төлөвтэй талбай хэмээн ойлгогддог. Улаан талбайд гадаргуун чулуун дээжлэлт болон урсгал сарнилын хүрээний дээжлэлт хийн, алт, зэс болон молибденийн хэд хэдэн хуримтлал бүхий гажил байгааг тогтоосон. Мөн геофизикийн судалгаа хийж цаашид үргэлжлүүлэн судлах хэд хэдэн хэтийн төлөвт бүсийг дараагийн өрөмдлөгийн бүсээр тогтоосон.

Алтан Нар

Алтан Нар орд нь Баянхөндий ордоос баруун хойд зүгт 16 км-т орших Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрлийн 4669 га талбайд оршдог. Компани ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2020 оны 3-р сарын 5 өдөр АМГТГ-аас авсан бөгөөд нийт 30 жилийн хугацаатай, нэмж 20 жилээр хоёр удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлийн талбай нь 5.6 х 1.5 км эрдэсжсэн бүс бөгөөд энэхүү бүсэд 18 (алт, мөнгө, хар тугалга, цайр) хэтийн төлөвт хайгуулын талбайг тодорхойлсон. Анхны хоёр нээлт болох “Нээлтийн бүс” (“НБ”) болон “Хойд Холбоо” (“ХХ”) бүсүүд нь Эрдэнэ Ресурсийн 2018 оны 2-р улиралд гаргасан нөөцийн шинэчилсэн тайланд мэдээлснээр хамгийн ихээр судлагдсан газрын гадаргууд дөт гүнд өндөр агуулгатай бүсүүдийг агуулдаг.

Алтан Нар нь карбонат-полиметаллт алтны (“СВМГ”) орд гэж үзэж байгаа ба Карбонат-полиметаллт алтны орд нь эпитеpmаль ордын дэд бүлэгт хамаардаг ба Баррик Гоулдын Поргера уурхай (Папуа Шинэ Гвиней), Рио Тинтогийн олборлож байсан Келиан уурхай (Индонези), Лундинын Фрута Дел Норте (Эквадор), Континентал Гоулдын Буритика төсөл (Колумби) зэрэг ордууд нь энэ төрөлд багтдаг. Энэ төрлийн ордууд нь ерөнхийдөө нуман тогтоц (арлан нум г.м.) дахь порфирийн интрузивын дээд хэсэгт тохиолдох ба хүдэржилт нь 500 гаруй метр гүн үргэлжлэх боломжтой байдаг.

Өнгөрсөн жилүүдэд Компани нь Баянхөндий төсөлд төвлөрөн ажилласан тул Алтан Нар төслийн талбайд хязгаарлагдмал хайгуул хийгдсэн. Нээлтийн бүсэд 2019 оны 4-р улиралд нийт 667 тууш метр өрөмдлөгийн судалгаа хийсэн. Нээлтийн бүсэд урьд нь өрөмдлөг хийж байгаагүй 70 метр талбайд (“Gar Zone”) өндөр агуулга бүхий цөмийг судлахаар 130 метрийн гүн дөрвөн цооног өрөмдсөн. Ордыг өмнө зүгт тэлэх боломжтой талбайг тав дахь цооногоор шалгасан. 2019 оны хайгуулын хөтөлбөрийн үр дүнгээр 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон бөгөөд үүний 7 метрийн интервал нь 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байсан (TND-135) нь өнөөг хүртэл хамгийн өндөр үр дүнд тооцогдож байна. 2019 оны үр дүнгүүд нь урьд нь бага агуулга бүхий нөөцийн блокуудын гадна оршиж, Нээлтийн бүсийн өндөр агуулга бүхий цөмийг тэлж, өндөр агуулга бүхий хүдэржилт тууштай үргэлжилж буйг харуулсан. Өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн нь Алтан Нарын нөөцөд эергээр нөлөөлж, дүүргийн бусад бүсүүдэд тэлэлт хийх боломжийг нээж байна. Өрөмдлөгийн хөтөлбөр нь Нээлтийн бүсийн өмнө зүгийн дагуу структурын коридорын дагуу аномаль алт, суурь металл тууштай үргэлжилж буйг харуулсан. Ирээдүйн хөтөлбөрүүдээр үргэлжлүүлэн судална.

Өнөөг хүртэл, Нээлтийн бүс ба Хойд Холбоо талбайд бодитой нөөц тодорхойлогдсон. Алтан Нарын үлдсэн 16 хэтийн төлөв бүхий талбайд Компани үргэлжлүүлэн хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлж, эрдэсжсэн системийн ойлголтыг бататгахаар төлөвлөсөн. RPMGlobal нь 2018 оны 5 сард Алтан Нарын эрдсийн нөөцийн тооцооллыг танилцуулахдаа хэд хэдэн захын агуулгыг тооцсон бөгөөд RPMGlobal Баянхөндийн ил уурхайн нөөцийг 0.7 г/т алттай дүйцэх нэгж2 (Доорх тэмдэглэлийн 8 дахь зүйлтэй танилцана уу) харин ил уурхайгаас доош гүнд орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т-оор тооцоолохыг зөвлөсөн. Алтан Нар алт-полиметаллын төслийн геологийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээллийг 2021 оны 3-р сарын 29-нд танилцуулсан Алтан Нар алтполиметаллын төслийн NI 43-101 техникийн тайлангаас авч танилцана уу.

Захын агуулга AuEq2 г/т	Нөөцийн агуулга	Тоо хэмжээ (сая.т)	Агуулга					Агуулсан металл				
			Au	Ag	Zn	Pb	AuEq2	Au	Ag	Zn	Pb	AuEq2
			г/т	г/т	г/т	г/т	г/т	Koz	Koz	Kt	Kt	Koz
0.7	Бодитой	5.0	2.0	14.8	0.6	0.6	2.8	318	2,350	31.6	29.0	453
	Боломжтой	3.4	1.7	7.9	0.7	0.7	2.5	186	866	23.7	22.3	277

Тэмдэглэл:

- (1) Ил уурхайн нөөцийт 0.7 г/т, ил уурхайгаас гүнд буй нөөцийн захын агуулгыг 1.4 г/т AuEq байхаар тоо.
- (2) Энэхүү нөөцийн тайлан дахь мэдээллүүд нь RPM-ийн ажилтан, Австралийн Геосудлаачдын Институтын гишүүн Жереми Кларк (Jeremy Clark)-ийн хяналт дор боловсруулагдсан. Ноён Кларк нь дурдсан ордын хүдэржилтийн талаар өндөр туршлагатай бөгөөд CIM Тодруулгын стандартын дагуу Мэргэшсэн этгээдийн шаардлага хангасан мэргэжилтэн юм.
- (3) Нөөцийн тайлангийн талаар дээрх хүснэгтэд багтсан мэдээлэл нь 2018 оны 5-р сарын 7 хүртэл хийгдсэн өрмийн судалгааны үр дүнд тулгуурласан. Нөөцийн тайлан нь нарийн өгөгдөл биш бөгөөд судалгааны үр дүн, байршил, хэлбэр болон тархац зэрэг хязгаарлагдмал мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан. Дээр өгөгдсөн өгөгдлүүд нь тооцооллын харьцангуй байдалд тулгуурлан бүхэл тоонд шилжүүлсэн болно. Үүнээс шалтгаалсан тооцооллын зөрүү гарах магадлалтай
- (4) Тайланд тусгагдсан нөөцийн агуулга нь CIM стандартын дагуу тайлагнагдсан
- (5) Нөөцийн тайланг хуурай, газар дээрх төлөвт нь үндэслэн тайлагнасан.
- (6) Нөөцийн тайланд бохирдол болон хүдрийн алдагдлын хүчин зүйлсийг багтаагаагүй.
- (7) Олборлолт хийгдэх болсон тохиолдолд металл авалтын алдагдал гарах магадлалтай.
- (8) AuEq буюу алттай дүйцэх нэгж2 нь алтыг нэг унц US\$1,310, мөнгийг нэг унц US\$18, хар тугалга нэг тонныг US\$2,400 цайрыг нэг тонныг US\$3,100 байхаар тооцоолсон.

Алтан Нар ордын дэлгэрэнгүй мэдээллийг SEDAR-т байршуулсан бөгөөд "Altan Nar Gold-Polymetallic Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia, National Instrument 43-101 Technical Report" нэртэйгээр 2021 оны 3-р сарын 29-нд бүртгүүлсэн.

Зуун Мод молибден-зэсийн төсөл

Зуун Мод нь молибден-зэс порфирийн орд бөгөөд Монголын баруун өмнөд хэсэгт оршино. Улаанбаатар хотоос баруун урд зүгт ойролцоогоор 950 км, Монгол-Хятадын хил Сэхээ боомтоос 215 км зайд байрладаг. Төсөл нь нийт 6041 га талбай бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. Энэ ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Компанийн охин компани болох Аниан Ресорсиз ХХКийн эзэмшилд байдаг ба ашиглалтын тусгай зөвшөөрөл нь эхний 30 жилийн хугацаанд явж байна. Энэ төслийг Галлант Минералз Лимитэд компаниас 2005 онд авсан бөгөөд Галлант Минералз компанид буцаан худалдаж авах нөхцөлтэйгөөр 1.5%-ийн нөөцийн төлбөр төлөх үүрэг хүлээсэн.

Компани нь 2011 онд NI 43-101 стандартын дагуу Зуун Модын нөөцийг тооцоолон олон нийтэд ил болгосон. Захын агуулгыг 0.04% молибден гэж тооцон, дунджаар 0.057% молибден болон 0.069% зэсийн агуулгатай 218 сая тоннын ("Сая тн") баталгаатай ба бодит нөөцтэй гэж тооцоолсон. Энэ нь 273.5 сая фунт металл молибден агуулсан болон 330.7 сая фунт металл зэстэй тэнцэнэ. Үүнээс гадна Зуун Модод дунджаар 0.052% молибден болон 0.065% зэсийн агуулгатай 168 сая тн таамаг нөөц байгаа ба энэ нь 191.8 сая фунт металл молибден агуулсан болон 240.5 сая фунт металл зэс агуулсан байдалтай байна.

2023 онд Зуун Мод төслийн талбайд 4,100 метрийн 12 цооног өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн. Ордын төв хэсэгт (ZMD-131 цооног) өндөр агуулга бүхий хүдэржилт үргэлжилж буйг шалгах болон бодитой нөөцийн бүсийн зэргэлдээ (ZMD-132-с 135 цооног) үргэлжлэлийг тэлэх зорилтын хүрээнд нийт 2476 тууш метрийн 5 цооног өрөмдсөн. Түүнээс гадна, Зуун Мод порфирийн системийн хүрээнд 1619 тууш метр 7 цооног (ZMD-136 to 142) өрөмдөв.

ZMD-131 цооногт 0.140% Мо ба 0.121% Си агуулсан 29 метрийн интервал (252-с 280 метр) багтаасан 0.080% Мо дундаж агуулга бүхий хэд хэдэн бүсийг (28-с 74 метрийн өргөн) огтолсон ба эдгээр бүсүүд нь дундаж агуулга 0.053% Мо ба 0.072% Си бүхий 374 метрт багтаж байна. Зуун Модын бодитой нөөцийн бүсийн (ZMD-132-135 цооног) хязгаар дагуу өрөмдсөн дөрвөн цооног нь 40-187 метрийн зузаан (>0.04% Мо) нөөцийн зэрэглэлийн хүдэржилт огтолсон. Зуун Мод порфирийн цогцолборын хойд бүсэд өрөмдсөн хэд хэдэн хайгуулын цооногуудад (ZMD -140-142 цооног) аномаль зэсийн хүдэржилт (0.05% Си-с дээш) илэрсэн. Төв ордын бүсээс баруун зүгт 1 км-т зүүнээс баруун тийш 600 метр хамарсан талбайд гурван цооног өрөмдсөнд аномаль молибден, зэс ба мөнгөний утга илэрсэн. Хайгуулын цооног болох молибденийн хүдрийн биетээс хойд зүгт 1.7 км-т өрөмдсөн ZMD-139 цооногт (одоогоор ZMD-135 цооног тодорхойлогдож буй) их хэмжээний молибденийн хүдэржилт огтолсон нь (0.067% Мо бүхий 12 метр) Зуун Мод порфирийн цогцолборт нийтлэг тохиолддог порфит гранодиорит агуулсан. Одоогоор Зуун Мод орд болон энэхүү цооногийн хооронд өрөмдлөг хийгдээгүй бөгөөд ирээдүйд томоохон талбайд эрдэсжилт нээх боломжийг бий болголоо.

Молибден-зэсийн порфирийн ордоос гадна, тусгай зөвшөөрлийн талбай нь Зуун Мод ордоос хойд зүгт ойролцоогоор 2.2 км-т орших зэс-мөнгөний томоохон хэтийн төлөв бүхий талбайг агуулдаг. Тус

хэтийн төлөв бүхий талбайн хайгуулын ажилд геологийн зураглал, судлын нягтаршлын зураглал, геохимийн дээжлэлт, геофизикийн судалгаа болон хол алслалттай өрөмдлөгийн ажлуудыг хийсэн. Өмнө нь хийсэн геофизикийн гажилтай цэг шалгах өрөмдлөгийн судалгаагаар 308-342 метр гүнд 1.3% зэс болон 9.24 г/т мөнгөний агуулгатай 34 метрийн интервал (ZMD-121) огтолсон. Нэмэлтээр хийсэн өрөмдлөгийн ажлаар том хэмжээний буюу 900 метр үргэлжлэх, зэсийн хэд хэдэн хүдэржсэн бүс байгааг илрүүлсэн. Өрөмдсөн гурван цооногт 0.2%-аас илүү зэсийн агуулгатай тодорхой интервалууд (12-42 метр) огтлогдсон.

2021 оны сүүлээр RPMGlobal-аас хийсэн урьдчилсан үнэлгээ дээр тулгуурлан ирэх саруудад зах зээл, техник, эдийн засгийн судалгаа, тусгай зөвшөөрөл авах ажлуудыг гүйцэтгэнэ. Хайгуулын хөтөлбөрийн болон судалгааны үр дүнд үндэслэн Компани нь төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх стратеги боловсруулна.

Зуун Мод ордын нөөцийн тайланг SEDAR-т байршуулсан бөгөөд "Technical Report Zuun Mod Porphyry Molybdenum-Copper Project, South-Western Mongolia, National Instrument 43-101 Independent Technical Report" нэртэйгээр 2011 оны 6-р сард бүртгүүлсэн.

Хөрөнгө оруулалт

Монгол Улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам хайгуулын тусгай зөвшөөрлийг олгодог. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, хэтийн төлөвтэй талбайнуудыг тодорхойлсон. Энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна. Түүнээс гадна хувийн өмчийн хуулийн этгээдүүдтэй хэлцэл хийх замаар тусгай зөвшөөрлийн талбайг эзэмших боломжуудыг судалсаар байна. Монголиан Майнинг Корпорэйшн-тэй хийсэн стратегийн түншлэлийн хүрээнд Эрдэнэ Ресурс нь Хөндий Эрдсийн Дүүрэгт тендер болон тусгай зөвшөөрөл эзэмших боломжуудыг судлан, оролцоно. Монгол Улсад урт хугацаанд ажилласан туршлагатай гадаадын хайгуулын компанийн хувьд үнэт болон суурь металлын хүрээнд цаашид тэлэх боломжуудыг судална.

Санхүүгийн тайлангийн онцлох мэдээлэл

Доорх санхүүгийн мэдээлэлд 2021, 2022, 2023 оны 12 сарын 31-ний байдлаар аудитлагдсан, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн мэдээллийг тусгав (Үнэт цаасны тоо хэмжээнээс бусад нь канад доллараар илэрхийлэгдсэн):

12 сарын 31-нд дуусгавар болсон	2023	2022	2021
Орлого	Nil	Nil	Nil
Алдагдал	\$ (522)	\$ 5,986	\$ 5,571
Нэгж хувьцаанд ногдох суурь ба хорогдуулсан алдагдал	\$ 0.00	\$ 0.02	\$ 0.02
Нийт хөрөнгө	\$ 59,063	\$ 52,533	\$ 46,544
Нийт урт хугацааны өр төлбөр	-	\$ 23	\$ 86

Үйл ажиллагааны хэлэлцүүлэг

2022, 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн мэдээлэл

Доорх хүснэгтэд 2022, 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд хайгуул болон үнэлгээний зардлыг харуулав. Үүнд Баянхөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг ЭМ-н зардлууд орсон. 2023 оны 12 сарын 31-р дуусгавар болсон тайлант жилд Баянхөндий, Алтан Нар, Улаантай холбоотой зардлууд нь ММС-тэй хийсэн Стратегийн түншлэлийн хүрээнд хяналтыг алдсанаар хараат компанид оруулсан хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагаа гэж тайлагнасан.

2023.12.31 байдлаар	Баянхөндий	Алтан Нар	Улаан	Зуун Мод ба бусад	Ерөнхий ба захиргаа	Нийт
Хайгуул, үнэлгээний зардал						
Кемп, талбайн зардал	\$ 673,282	\$ 24,436	\$ 65,687	\$ 435,626	\$ -	\$ 1,199,031
Өрөмдлөг, судалгаа	180,302	9,463	2,883	574,466	-	767,114
Уурхайн судалгаа, бэлтгэл ажил	1,940,377	50,966	29,938	116,677	-	2,137,958
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	-	-	994,595	994,595
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	-	-	664,229	664,229
Оролцогч талуудтай харилцах	1,299,924	129,875	-	29,306	-	1,459,105
Томилолт ба бусад	44,343	-	-	-	-	44,343
Нийт хайгуулын зардал	4,138,228	214,740	98,508	1,156,075	1,658,824	7,266,375
Капиталжуулсан зардал	-	-	-	(1,043,280)	-	(1,043,280)
Түншийн гаргасан зардал	(4,138,228)	(214,740)	(98,508)	-	(924,609)	(5,376,085)
2023 онд зарлагдсан хайгуулын зардал	\$ -	\$ -	\$ -	\$ 112,795	\$ 734,215	\$ 847,010
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2023.1.01	\$ 36,183,734	\$ 4,257,954	\$ 1,688,477	\$ 923,991	\$ -	\$ 43,054,156
Түншийн хайгуул, үнэлгээний хөрөнгийн нэгтгэл	\$(36,183,734)	\$(4,257,954)	\$(1,688,477)	-	-	\$(42,130,165)
Нэмэлт	-	-	-	1,043,280	-	1,043,280
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	-	-	-	(5,765)	-	(5,765)
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2023.12.31	\$ -	\$ -	\$ -	\$ 1,961,506	\$ -	\$ 1,961,506

2022.12.31 байдлаар	Баянхөндий	Алтан Нар	Улаан	Зуун Мод ба бусад	Ерөнхий ба захиргаа	Нийт
Хайгуул, үнэлгээний зардал						
Кемп, талбайн зардал	\$ 3,123,489	\$ 159,478	\$ 466,088	\$ 233,073	\$ -	\$ 3,982,128
Өрөмдлөг, судалгаа	764,631	10,075	738,295	2,580	-	1,515,581
Уурхайн судалгаа, бэлтгэл ажил	3,502,309	107,541	87,324	56,757	-	3,753,931
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	-	-	1,102,603	1,102,603
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	-	-	420,225	420,225
Оролцогч талуудтай харилцах	810,678	944	375	12,825	-	824,822
Томилолт ба бусад	127,835	11,341	11,116	21,049	-	171,341
Нийт хайгуулын зардал	8,328,942	289,379	1,303,198	326,284	1,522,828	11,770,631
Капиталжуулсан зардал	(7,628,060)	(288,818)	(1,726)	(53,351)	-	(7,971,955)
2022 онд зарлагдсан хайгуулын зардал	\$ 700,882	\$ 561	\$ 1,301,472	\$ 272,933	\$ 1,522,828	\$ 3,798,676

Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2022.1.01	\$ 30,910,999	\$ 4,246,301	\$ 1,797,500	\$ 973,653	\$ -	\$ 37,928,453
Нэмэлт	7,628,060	288,818	1,726	53,351	-	7,971,955
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(2,355,325)	(277,165)	(110,749)	(103,013)	-	(2,846,252)
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2022.12.31	\$ 36,183,734	\$ 4,257,954	\$ 1,688,477	\$ 923,991	\$ -	\$ 43,054,156

Хайгуул болон үнэлгээний өртөг нь 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд \$847,010 байсан нь өмнө оны мөн үеийн \$3,798,676-аас буурсан. Энэ нь ММС-тэй байгуулсан Стратегийн түншлэлийн хүрээнд ЭМ дахь хяналтыг алдсанаар ЭМ-ын үйл ажиллагааг хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт болгон бүртгэж, Эрдэнэ Ресурсийн бүсийн хайгуулын ажлуудын зардлыг хэсэгчлэн тэнцүүлснээс үүдэлтэй.

Капиталжуулсан зардал оролцуулсан Эрдэнэ Монгол ХХК-ийн хайгуул болон үнэлгээний өртөг нь 2023 оны 12 сарын 31-ний байдлаар \$7,266,375 байсан ба 2022 оны мөн үеийн капиталжуулсан зардал оролцуулсан хайгуул болон үнэлгээний өртөг \$11,770,631 байна. Өрөмдлөгийн хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 10,000 тууш метр өрөмдсөн ба 2023 онд 5,000 тууш метр өрөмдсөн. Мөн Баянхөндий алтны төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлсэнтэй холбоотойгоор 2023 оны хоёрдугаар хагаст техникийн судалгааны ажилд бага зардал зарцуулсан.

2023 оны 12 сарын 31-ний байдлаар кемп, талбайн зардал өмнө жилийн мөн үетэй харьцуулахад \$2,783,097-аар буурсан нь хайгуулын хөтөлбөрүүд багасахаас гадна тус кэмп, талбайн зардлын тодорхой хувь нь Баянхөндий төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын зардал руу шилжсэнтэй холбоотой.

Өрөмдлөг, судалгааны зардал 2023 оны 12 сарын 31-ний байдлаар өмнө оны мөн үеэс \$748,467 доллараар бага байсан нь 2023 онд хайгуулын ажил бага гүйцэтгэсэнтэй холбоотой.

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар уурхайн судалгаа, бэлтгэл ажлын зардал 2022 оны мөн үеэс \$1,615,973 доллараар бага байсан нь 2023 оны ТЭЗҮ-ийн ажилд зарцуулсан дүн өмнө жилийн инженерчлэл болон зураг төслийн зардлаас бага байсантай холбоотой.

Монгол дахь оффисын зардал 2023 оны 12 сарын 31-ний байдлаар өмнө жилийн мөн үеэс \$108,008 бага байсан. Энэхүү хугацаанд маркетинг сурталчилгааны зардал бага байсан ч ММС-тэй байгуулсан түншлэлтэй холбоотой хуулийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээний зардал өссөн.

Хувьцаанд суурилсан урамшуулал нь 2023 онд өмнө жилийн мөн үеэс \$244,004-аар өссөн нь өнгөрсөн онд компанийн олгосон опционы тоо хэмжээ болон хувьцааны ханш өссөнөөс үүдэн опционы үнэлгээ өссөнтэй холбоотой.

Оролцогч талуудтай харилцахад зарцуулсан зардал 2023 оны 12 сарын 31-ний байдлаар өмнө оны мөн үеэс \$634,283-аар өндөр байсан. Энэ нь “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-ний дүн болон орон нутагт оруулсан хөрөнгө оруулалттай холбоотой. Жишээлбэл, Шинэжинст сумд Ундны усны хангамжийг сайжруулах хөтөлбөр гүйцэтгэсэн.

Томилолт болон бусад зардал өмнө жилийн мөн үеэс \$126,998-аар бага байсан нь Баянхөндий алтны төсөлтэй хамааралтай олон улсын томилолтын зардлыг хөрөнгө, боловсруулах үйлдвэр ба тоног төхөөрөмжийн зардалд оруулан капиталжуулсан.

Доорх хүснэгтэд 2022, 2023 оны 12 сарын 31-ний байдлаар ерөнхий ба захиргааны зардлуудыг харуулав.

	12 сарын 31-ны байдлаар		Өөрчлөлт
	2023	2022	
Захиргааны үйлчилгээ	\$ 935,025	\$ 703,051	\$ 231,974
Элэгдэл, хорогдол	36,958	38,089	(1,131)
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр	122,244	126,754	(4,510)
Хөрөнгө оруулагчтай харилцах, мар	318,225	124,672	193,553
Оффис ба бусад	105,686	102,738	2,948
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	504,095	380,691	123,404
Зохицуулагч байгууллагын төлбөр	109,322	115,853	(6,531)
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	902,280	584,920	317,360
Томилолтын зардал	103,900	42,216	61,684
	\$ 3,137,735	\$ 2,218,984	\$ 918,751

Захиргааны зардал 2023 оны 12 сарын 31-ний байдлаар \$3,137,735 байсан нь 2022 оны мөн үеийн \$2,218,984 -аас өссөн дүн юм.

Захиргаа үйлчилгээний зардал 2023 оны 12 сарын 31-ний байдлаар өмнө жилийн мөн үеийнхээс \$231,974-өөр илүү байсан нь ММС-тэй байгуулсан стратегийн түншлэлийн хүрээнд захиргааны удирдлагын зардал нэмэгдсэн, инфляцтай уялдсан цалингийн зардал өссөнтэй холбоотой.

Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг 2023 оны 12 сарын 31-ний байдлаар өмнө жилийн мөн үеэс \$193,553 -аар өссөн байна. Энэ нь ММС-тэй байгуулсан стратегийн түншлэлийн хүрээнд хийгдсэн маркетинг болон олон нийтийн маркетингийн хөтөлбөрийг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

2023 оны 12 сарын 31-ний байдлаар мэргэжлийн үйлчилгээний төлбөр өмнө жилийн мөн үеэс \$123,404 -өөр өссөн. Энэ нь хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд санхүүгийн зөвлөхүүдтэй хамтарч ажилласантай холбоотой.

Хувьцаанд суурилсан урамшуулал нь 2023 онд өмнө жилийн мөн үеэс \$317,360-аар өссөн нь өнгөрсөн онд компанийн хувьцааны үнэлгээ нэмэгдсэнтэй холбоотойгоор опционы үнэлгээ болон олгосон тоо ширхэг нэмэгдсэнтэй холбоотой.

Томилолт болон бусад зардал өнгөрсөн оны мөн үеэс \$61,684 -ээр өссөн нь хөрөнгө оруулагчидтай харилцах, компанийн үйл ажиллагааг дэмжих ажлуудтай холбоотой томилолт нэмэгдсэнтэй холбоотой.

Элэгдэл, хорогдол, ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, оффис ба бусад зардлууд болон зохицуулагч байгууллагын төлбөр 2023 оны 12 сарын 31-ний байдлаар өмнөх тайлант үеийнхээс их хэмжээний материаллаг өөрчлөлт ороогүй.

Дөрөвдүгээр улирал

Хайгуул, үнэлгээний зардал 2023 оны 12-р сарын 31-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд нийт \$42,543 байсан ба үүнд хайгуулын багийн цалин болон холбогдох зардлууд багтсан.

2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон 3 сарын хугацаанд Эрдэнэ Монгол ХХК-ийн нийт хайгуулын зардал \$1,613,318 байсан. Хайгуул, хээрийн ажлын зардал \$215,396 байсан нь 2023 онд хийсэн хайгуулын хөтөлбөрийн хүрээнд техникийн баг болон кэмгийн зардалд зарцуулагдсан. Уурхайн судалгаа болон зөвшөөрлийн зардлууд нь \$275,515 байсан нь нөөц болон техникийн судалгааны ажлуудад чиглэсэн. Оролцогч талуудтай харилцах зардалд \$785,183 зарцуу Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээтэй холбоотойгоор \$785,183 зардал оролцогч талуудтай харилцах зардалд тусгагдсан. Бусад хайгуулын зардлууд болох \$337,224-д томилолтын зардал, Компанийн Монгол Улс дахь хээрийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий зардлууд болон Монгол дахь оффисын зардал багтсан.

2023 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон 3 сарын хугацаанд ерөнхий болон захиргааны зардал \$565,575 байснаас цалин болон захиргааны зардал \$180,757, зохицуулагч байгууллагын зардал \$32,714, мэргэжлийн үйлчилгээний зардал \$154,991, хувьцаанд суурилсан нөхөн төлбөр \$61,282 байсан бөгөөд томилолт, хөрөнгө оруулагчтай харилцах зэрэг бусад захиргааны зардлууд \$135,831 багтаж байна.

Улирлын үр дүнгийн хураангуй

Хувьцааны тоо хэмжээнээс бусад дүнг мянган канад доллараар илэрхийлэв.

	Санхүүгийн жил 2023				Санхүүгийн жил 2022			
	Q4	Q3	Q2	Q1	Q4	Q3	Q2	Q1
	12 сар	9 сар	6 сар	3 сар	12 сар	9 сар	6 сар	3 сар
Алдагдал	\$1,583	\$2,144	\$2,796	(\$7,045)	\$1,077	\$1,980	\$1,698	\$1,231
Нэгж хувьцаанд ногдох алдагдал	\$0.00	\$0.01	\$0.01	(\$0.02)	\$0.00	\$0.01	\$0.01	\$0.00
Нийт хөрөнгө	\$59,063	\$60,663	\$62,478	\$64,162	\$52,533	\$47,785	\$42,495	\$44,230

2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд Компани нь \$1,583,187 долларын цэвэр алдагдалтай байсан ба 2022 оны мөн үед \$1,076,895 доллар байсан.

Компанийн зардал нь Монгол дахь хайгуулын хөтөлбөрүүдээс хамаарч улирал тутамд харилцан адилгүй байдаг. Компани нь өнгөрсөн хугацаанд санхүүгийн үр дүнд нөлөөлж болохуйц мэдээ болон тодорхой чиг хандлагын тухай мэдээлэл аваагүй болно.

Төлбөр гүйцэтгэх чадвар болон капитал нөөц

Энэхүү УХДШ гарах өдрөөр Компанийн бэлэн мөнгө \$3.3 сая канад доллар, эргэлтийн хөрөнгийн хэмжээ ойролцоогоор \$4.6 сая канад доллар байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компанийн Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх (Хайгуул, хөгжүүлэлтийн төслүүд ба Үйл ажиллагааны хэлэлцүүлгээс танилцана уу), тэдгээрийг дэмжих захиргааны зардлуудыг санхүүжүүлэхэд зарцуулсан. Компани нь өөрийн хайгуулын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх чадвар нь ММС-тэй хийсэн стратегийн түншлэл, хөрөнгө борлуулах, опцион болон хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулах болон/эсвэл өр төлбөрөөр санхүүжих зэргээр тодорхойлогдоно. Нэмэлт санхүүжилт хийх хугацаа, боломж, төлөвлөлт нь ММС-тэй хийсэн стратегийн түншлэлийн 3-р үе шатыг эцэслэх, төслийн санхүүжилтийн судалгаа

хэлэлцээр болон компанийн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүн болон зах зээлийн нөхцөл байдлаас хамаарна.

Компанийн орлогын эх үүсвэр хязгаарлагдмал тул мөнгөн гүйлгээнд дүн шинжилгээ хийх эсвэл ямарваа нэг бодитой чиг хандлагыг тодорхойлоход бэрхшээлтэй. Компани нь хайгуулын болон төсөл хөгжүүлэлтийн хөтөлбөрүүдээ нэмэлт хувьцаа гаргах замаар хувьцааны санхүүжилт татан төвлөрүүлснээр санхүүжүүлж байна.

Энд дурдсан төлөвлөгөөт зардлаас бусдаар Компани нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, урьдчилан тооцоолж болохуйц ирээдүйн капитал хөрөнгө материаллаг байдлаар өсөх/буурах аливаа чиг хандлага, шаардлага, үүрэг, үйл явдал, тодорхой бус байдлын талаар мэдээлэл байхгүй болно.

Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй

Гаргасан ба эргэлтэд буй хувьцаат капитал

	2024.03.27	2023.12.31
Гаргасан ба эргэлтэд буй энгийн хувьцааны тоо	345,538,176	344,888,176
Опцион	25,415,000	20,485,000
Варрант	25,264,122	25,264,122
ИОХЭ	8,442,250	8,442,250
Нийт гаргасан санхүүгийн хэрэгсэл	404,659,548	399,079,548

Гэрээгээр хүлээсэн үүрэг

Дараах хүснэгтэд 2023 оны 12 сарын 31-ний байдлаар Компанийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулав:

	Нийт	>1 жил	1-2 жил
Оффисын түрээс	\$22,939	\$22,939	\$ -
Дансны өглөг ба хуримтлагдсан өр төлбөр	163,212	163,212	-
	\$186,151	\$186,151	\$ -

Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг

ММС стратегийн түншлэл

2023 оны 1-р сард Эрдэнэ Ресурс нь ММС-тэй стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан. ММС нь \$40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн 50%-тай тэнцэх хувьцааг эзэмших нөхцөлтэй гэрээ байгуулсан. Энэхүү хөрөнгө оруулалтийн нөхцөлүүдийг хангагдаж хөрвөх нөхцөлтэй хөрөнгө 2024 оны 1 сарын 23-ны өдөр эцэслэгдэн шилжсэн. Эрдэнэ Ресурс нь ЭМ-ийн 50%-ийг эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн орчимд 700км² -ийн хүрээнд эзэмших тусгай зөвшөөрлүүд дээр 5%-ийн борлуулалтын орлогын төлбөр ("Net smelter return" буюу "NSR") (цаашид "БОТ" гэх) авах нөхцөлтэй.

Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор 2024 оны 2-р сарын 8-ны өдөр Эрдэнэ Ресурс нь ММС-тэй төслийн санхүүжилтийн гэрээг байгуулав. Эрдэнэ Ресурс болон ММС нар нь Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Монгол ХХК ("ЭМ")-ийг хамтран эзэмшдэг ба тус санхүүжилт нь ММС-ээс хувь эзэмшигчийн зээлийн нөхцөлөөр олгогдох юм.

Баянхөндий төслийн бүтээн байгуулалтад хувь эзэмшигчийн зээл хэлбэрээр 50 сая ам.долларын санхүүжилт хийгдэнэ. Тус санхүүжилт нь таван үе шаттайгаар хийгдэх ба нэг удаагийн санхүүжилт 5 сая ам.доллараас багагүй байна. Зээлийн хугацаа нь олгогдсон өдрөөс таван жилийн хугацаатай ба 13.8%-ийн хүүтэй, улирал бүр төлөх төлбөрийн нөхцөлтэй. ЭМ нь хүү төлөлтийн эхний дөрвөн хүүгийн төлбөрийг капиталжуулах боломжтой ба зээлийг хугацаа дуусахад бүрэн төлсөн байх

нөхцөлтэй. Үлдсэн 30 сая ам.долларыг зээлийн адил нөхцөлтэйгөөр MMC олгох боломжтой ба Эрдэнэ Монгол ХХК нь Монгол Улсын арилжааны банкуудаас 30 сая ам.доллар хүртэл санхүүжилт татах боломжуудыг давхар судалж байна.

Зээлийн хүрээнд Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол дахь өөрийн эзэмшлийн 50% болон Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эзэмших борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх)-ийг барьцаа хөрөнгө болгоно. Зээлийн эргэн төлөгдөх хугацаанд талуудын хооронд байгуулсан Стратегийн түншлэлийн гэрээний дагуу MMC давуу эрхийн саналтай байх бөгөөд Эрдэнэ Ресурсийн Зуун Мод төслийн хувьд тэргүүн ээлжид татгалзах эрх эдэлнэ. Эрдэнэ Ресурс нь MMC-тэй адил нөхцөлөөр зээлийн 50%-ийг хувьцаа эзэмшигчийн зээл хэлбэрээр олгох боломжтой.

Сэндсторм Гоулд (“Sandstorm Gold Ltd”) Роялти гэрээ

Сэндсторм Гоулд Лтд. (“Sandstorm”) нь Эрдэнэ Ресурсийн батламжилсан ЭМ-ын Алтан Нар болон Хөндий тусгай зөвшөөрлүүдэд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн (“NSR”) эрхийг эзэмшдэг. Сэндсторм нь Алтан Нар болон Хөндий тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ирээдүйн роялти санхүүжилтэд хориг тавих эрхтэй.

Бусад

Компани Зуун Мод тусгай зөвшөөрлийн борлуулалтын цэвэр ашгаас 1.5%-ийн төлбөрийг (“БЦАТ”) Сэндбокс Роялти Корп-д өгөх нөхцөлтэй. Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын судалгаа, ажил хийх үүрэг хүлээгээгүй.

Балансаас гадуурх зохицуулалт

Компани нь 2023 оны 12 сарын 31-ний байдлаар дээр дурдсан MMC-тэй хийсэн Стратегийн Түншлэлээс гадна батлан даалтын гэрээ, бусад байгууллагад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой болзошгүй үүрэг, үүсмэл хэрэгсэл буюу Компанид санхүүжилт, хөрвөх чадвар, зах зээлийн болон зээлийн эрсдэл учруулж болзошгүй аливаа үүрэг гэх мэт балансаас гадуурх аливаа зохицуулалт хийгээгүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тооцоолол

Эрдэнэ Ресурс нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулан, хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг бүртгэх дүн, хугацаанд нөлөөлөх тооцооллыг хийж бүртгэн СТОУС-н дагуу санхүүгийн тайланг бэлтгэн гаргадаг. Давагдашгүй тодорхойгүй нөхцөлтэй асуудлуудын хувьд шаардагдах үнэлэмжийг ашиглан зарим тооцооллыг хийж гүйцэтгэдэг.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйлсан тайлбар, тодорхойгүй нөхцөлтэй асуудлуудын тооцоолол буюу үүнээс хамаарч гарч болох эрсдэлийн улмаас хийгдэх залруулгын тухай хийгдэх тооцооллын гол эх сурвалжийг 2023 оны 12 сарын 31-ний нэгдсэн санхүүгийн тайлангийн тодруулга 2-т тусгасан. Эдгээр эх сурвалжууд нь санхүүгийн нэгдсэн тайланг бэлтгэн гаргахад чухал ба дараах гол эх сурвалжуудыг онцолсон болно:

- Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт дахь нөлөөллийг тодорхойлох;
- Хувьцаанд суурилсан урамшуулал

Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт дахь нөлөөллийг тодорхойлох

Компанийн охин компаниуд дахь хувь хэмжээ нь нөлөөллийн тодорхойлолтод нийцэж байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай бөгөөд ингэснээр өөрийн хөрөнгийн аргаар бүртгэнэ. Удирдлага нь хууль ёсны эзэмшлийн хувь хэмжээ, аж ахуйн нэгжүүдийн шийдвэр гаргах үйл явцад дүн шинжилгээ хийх замаар дээрх нөлөөллийг тодорхойлдог. Эрдэнэ Ресурс нь 2023 оны 1-р сарын 10-ны өдөр Эрдэнэ Монгол ХХК-ийн хяналтын хувь хэмжээг шилжүүлсэн даруйдаа удирдлага нь ЭМ олборлолтод чухал нөлөө үзүүлэх боломжтой гэдгээ тодорхойлж, энэ хөрөнгө оруулалтыг хувь нийлүүлэх аргын дагуу хараат компани гэж бүртгэсэн.

Хувьцаанд суурилсан урамшуулал

Ажилтнуудад олгосон хувьцаанд суурилсан урамшууллыг олгосон өдрийн бодит үнэ цэнээр (зах зээлд суурилагагүй баталгаажих нөхцөлийн нөлөөг тооцохгүй) бүртгэнэ. Бодит үнэ цэнийг BlackScholes үнэлгээний загварыг ашиглан тооцох ба ингэхдээ бодит үнэ цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд шийдвэр гаргаж үнэлэхийг шаарддаг. Компани нь 2023 оны 12 сарын 31-ний

өдрөөр дуусгавар болсон жилийн хугацаанд бэлэн бус, хувьцаанд суурилсан урамшуулалд нийт \$1,566,509 долларыг зарцуулсан (2022 - \$1,005,146).

Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт

Эрдэнэ Ресурс компани нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх дараах шинэчилсэн стандартуудыг дагаж мөрдсөн бөгөөд эдгээр өөрчлөлтийг холбогдох шилжилтийн заалтуудын дагуу хийсэн болно.

НББОУС 1 – Нягтлан бодох бүртгэлийн ил тод байдал

2021 оны 2-р сард НББОУС нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, СТОУС мэдэгдэл 2 Материаллаг байдлын дүгнэлт, НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооны өөрчлөлт ба алдаад нэмэлт өөрчлөлт оруулсан. Компани нь тус өөрчлөлтийн 2023 оны 1 сарын 1-с мөрдөж эхэлсэн. Нэмэлт өөрчлөлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогод ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй ч санхүүгийн тайланд тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэлд нөлөөлсөн. Нэмэлт өөрчлөлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг "чухал" гэхээсээ илүү "материал"-ыг тодруулахыг шаарддаг. Нэмэлт өөрчлөлт нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг ил тод болгоход материаллаг байдлыг ашиглан, хэрэглэгчдэд санхүүгийн тайлангийн бусад мэдээллийг ойлгоход тусалж, аж ахуйн нэгжид хамаарах нягтлан бодох бүртгэлийн бодлогод хэрэгцээтэй мэдээллээр хангахад юм. Удирдлага нэмэлт өөрчлөлттэй уялдуулан шаардлагатай тохиолдлуудад Тодруулга 3-т заасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээллүүдийг шинэчилсэн.

Санхүүгийн хэрэглүүр ба бусад эрсдэл

Санхүүгийн хэрэглүүр

Компанийн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн нь дансны үнэтэй ойролцоо гэж үздэг. Бодит үнэ цэн нь тооцох өдөр зах зээлд оролцогчдын хооронд хийсэн хэлцлийн дагуу хөрөнгийг худалдахад хүлээн авах эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлөх үнэ юм. Бодит үнэ цэний түвшин нь бодит үнэ цэнийг ангилан хэмжихэд ашигласан үнэлгээнд тогтоодог.

Түвшин 1: Хөрөнгө болон өр төлбөрийн зах зээл дэх үнэ

Түвшин 2: Түвшин 1-д тогтсон зах зээлийн үнээс бусад шууд болон шууд бусаар тогтоогдох үнэ

Түвшин 3: Зах зээлийн үнээс үл хамаарсан байдлаар тогтоогдох үнэ.

Бодит үнэ цэн

2023 оны 12 сарын 31 болон 2022 оны 12 сарын 31-ний өдөр дуусгавар болсон нэг жилийн хугацаанд 1, 2, 3-р түвшинд ангилсан хөрөнгө, өр төлбөрийн хооронд шилжүүлэг хийгдээгүй. Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн нь богино хугацаанд санхүүгийн хэрэглүүрийн хугацаа дуусахад дансны үнэ цэнтэй ойролцоо байна.

Зээлийн эрсдэл

Компани нь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг Канадын томоохон санхүүгийн институтэд хадгалуулж, бэлэн мөнгөний эрсдэлийг бууруулах боломжтой гэж Компанийн удирдлага үздэг. 2023 оны 12 сарын 31-ний байдлаар бэлэн мөнгөний үлдэгдлийн 1% буюу \$33,759 нь Канад Улсаас гадна банкуудад хадгалагдаж байна (2022 - \$268,376 буюу 4%).

Хөрвөх чадварын эрсдэл

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг. Компанийн бүх санхүүгийн өр төлбөрийг ирэх арван хоёр сарын дотор барагдуулахаар төлөвлөж байна.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

Хүүгийн эрсдэл

Компани нь бэлэн мөнгөний үлдэгдэлтэй мөн хөрвөх нөхцөлтэй зээлийн үлдэгдэлтэй, хөрвөх нөхцөл биелэгдээгүй тохиолдолд хүүний эрсдэлд орох магадлалтай. Компанийн одоогийн баримталж буй бодлого нь хүүгийн эрсдэлд орох боломжтой илүүдэл бэлэн мөнгийг хүүтэй хадгаламжийн дансанд байршуулж байна.

Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллараар зардлыг гаргасан. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, Монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад Улсын банкнуудад ам.доллар байршуулдаг.

Компанийн ам.долларын ханшийн эрсдэлд өртөх магадлалтай хөрөнгө 2023 оны 12 сарын 31-ний байдлаар \$1,044,829 (2022.12.31 - \$95,635) байна. Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$104,500 (2022.12.31 - \$9,600) долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай.

Компанийн монгол төгрөгийн ханшийн эрсдэлд өртөх магадлалтай хөрөнгө 2023 оны 12 сарын 31-ний байдлаар \$2,966 (2022.12.31 - \$43,479) байна. Төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$300 (2022.12.31 - \$4,300) долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай.

Үнийн эрсдэл

Компани нь тодорхой ашиггүй тул түүхий эдтэй холбоотойгоос бусад санхүүгийн хэрэгсэл, хайгуул, олборлолтын салбар дахь компаниудад нөлөөлдөг үнийн хэлбэлзэл, үнийн шууд эрсдэлд өртөхгүй.

Бусад эрсдэлүүд

Компани нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа голчлон хайгуулын үр дүн, тусгай зөвшөөрөл, санхүүжилттэй холбоотой эрсдэлтэй тулгардаг, түүнээс гадна металл болон түүхий эдийн үнэтэй холбоотой эрсдэл, тодорхой бус байдал үүсэх боломжтой. Ашигт малтмалын хайгуул, уул уурхайн үйл ажиллагааны хөгжүүлэлт нь олон эрсдэл дагуулдаг бөгөөд дийлэнх нь Компанийн хяналтаас давсан байдаг. Компани нь дэд бүтэц сул хөгжсөн алслагдмал байршилд үйл ажиллагаа явуулдгаас гадна хайгуул, ашиглалтын энгийн эрсдэлүүдтэй тулгарч байдаг. Эдгээр эрсдэлүүдийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй SEDAR+ www.sedarplus.ca-д байрлах Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс танилцах боломжтой.

Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт

Канадын үнэт цаасны зохицуулалтын 52-109 журмын дагуу санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлж байна. Гүйцэтгэх захирал (ГЗ), Санхүү хариуцсан захирал (СХЗ)-ыг багтаасан Эрдэнэ Ресурсийн удирдах баг (хамтад нь “Удирдах баг” гэх) нь санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Санхүүгийн тайлагналд тавих Эрдэнэ Ресурсийн дотоод хяналт (аудит) нь санхүүгийн тайлагналын найдвартай байдлыг хангаж, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд анхаарна.

Удирдлага нь 2023 оны 12 сарын 31-ний байдлаар Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтын хэрэгжилт, үр нөлөөг үнэлсэн. Ийнхүү үнэлэхдээ Удирдлага нь Ивээн тэтгэгч байгууллагуудын хороо (“Committee of Sponsoring Organizations of the Treadway Commission”)-ны “Дотоод хяналт - нэгдсэн зохицуулалтын орчин (2013)” гэх тайланд тогтоосон шалгууруудыг ашигласан. Үнэлгээгээр гол эрсдэлтэй салбаруудын хяналтыг шалгаж, эдгээр хяналтуудын хэрэгжилтийг үнэлж, үр нөлөөг нь тодорхойлох зорилгоор тэдгээр хяналтуудыг туршиж, үр дүнг нь хянаж, улмаар нэгдсэн дүгнэлт гаргасан.

Удирдлагын үнэлгээнд үндэслэн ГЗ болон СХЗ нар 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналт болон материаллаг сул тал нь санхүүгийн тайлагналын үнэн зөв, найдвартай байдлыг хангах, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд үр нөлөөтэй байна гэж дүгнэсэн.

Санхүүгийн тайлагналын дотоод хяналт дахь материаллаг сул талуудыг тодорхойлох

Компани нь 2023 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн хугацаанд удирдлагын зүгээс нарийвчилсан дүгнэлт хийх шаардлагатай гэрээ хэлэлцээрүүдийг СТОУС-ын дагуу боловсруулан, нэмэлт өөрчлөлтүүд оруулсан. Аудитын дүгнэлтээр тайлант хугацаанд СТОУС стандартын тодруулга болон хэрэгжилтийг сайжруулах шаардлагатайг тодорхойлсон. Үүнтэй холбогдуулан

санхүүгийн тайлагналын дотоод хяналтын хүрээнд санхүүгийн тайланд засвар оруулсан. Энэхүү материаллаг сул талыг удирдлага нь ЭМ-д оруулсан хөрөнгө оруулалтын нягтлан бодох бүртгэлийн үндэстэй холбоотой нарийвчилсан дүгнэлт гаргах шаардлагатай бол СТОУС-ын тодруулга, хэрэглээтэй холбоотой хяналтаар хязгаарлахаар тодорхойлсон.

Дээрх материаллаг сул талыг харгалзан удирдлага нь СТОУС-ын тодруулга, хэрэглээтэй холбоотой субъектив асуудал илрэх тохиолдолд хөндлөнгийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөн, тусламж авах үүрэг хүлээсэн.

Мэргэшсэн этгээд

Петер Далтон, P. Geo, (Нова Скошиа) нь NI 43-101 стандартын шаардлага хангасан мэргэшсэн этгээд бөгөөд Компанийн хайгуулын бүх геологийн хөтөлбөрийг удирдан чиглүүлнэ. Дээжийг Монгол Улсын Улаанбаатар хот эсвэл БНХАУ-ын Тяньжинд байрлах Эс Жи Эс лаборатори ("SGS Laboratories"), Улаанбаатар хот дахь Геологийн төв лаборатори, Канадын Бритиш Колумбийн муж дахь Блю Коуст Рисерч Лтд ("Blue Coast Research Ltd") эсвэл Канадын Ванкувер хотод төвтэй ALS Chemex лабораторид тус тус шинжлүүлдэг. Эс Жи Эс лаборатори, Геологийн төв лаборатори, ALS Chemex лабораторийн дотоод хяналтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн эрдэсжилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэдэг.

Энэхүү УХДШ-д толилуулсан Компанийн эзэмшиж буй ашигт малтмалын төслүүдийн шинжлэх ухааны болон техникийн мэдээллийг Компанийн мэргэшсэн мэргэжилтэн Петер Далтон (P. Geo) хянан баталсан болно.

Энэхүү УХДШ-д багтсан Баянхөндий ордын ТЭЗҮ-ийн санхүүгийн загвартай холбоотой мэдээлэл нь O2 Mining Limited-ийн ажилтан Марк Рэйнолдс ("Mark Reynolds")- ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд суурилсан болно. Энэхүү УХДШ дэх Баянхөндий ордын ТЭЗҮ-ийн хөрөнгө оруулалт ба үйл ажиллагааны зардлын тооцоотой холбоотой мэдээлэл нь FAusIMM ба O2 Mining Ltd компанийн захирал Жулиен Лауренс (Julien Lawrence)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд суурилсан болно. Энэхүү УХДШ дэх Баянхөндий ордын ТЭЗҮ-ийн боловсруулах үйлдвэрийн загварчлал болон алт авалтын аргачлалтай холбоотой мэдээллийг FAusIMM-ийн гишүүн ба O2 Майнинг ХХК-тай хамтран ажилладаг Жеффри Жардин (Jeffrey Jardine)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд үндэслэсэн болно. УХДШ дэх Баянхөндий ордын нөөцийн тооцооллыг AGP Mining Consultants Inc-ийн ажилтан Пол Даигл ("Paul Daigle"), P. Geo, боловсруулж, баталгаажуулсан. Баянхөндийн геологийн нөөцийн тооцооллыг Австралийн газар зүйн шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн, RPM Global компанийн ажилтан БатОчирын Оюунбат ("Oyunbat Bat-Ochir") боловсруулж баталгаажуулсан. Баянхөндийн үйлдвэрлэлийн нөөцийн тооцооллыг Жулиен Лауренс (Julien Lawrence)-ийн боловсруулсан, хянасан мэдээлэлд суурилсан болно. н.Рэйнолдс, Лауренс, Жардин, Даигл ба БатОчир нар нь энэ төрлийн орд болон эрдэсжилтийн төрлийн талаар өндөр мэдлэг туршлагатай, NI 43- 101-г тодорхойлсон мэргэшсэн мэргэжилтнүүд юм. Ноён Рэйнолдс, Лауренс, Жардин, Даигл ба Бат-Очир нар нь Эрдэнэ Ресурстай холбоотой ашиг сонирхлын зөрчилгүй.

Бусад мэдээлэл

Компанийн талаарх нэмэлт мэдээллийг SEDAR+ www.sedarplus.ca хаяг болон www.erdene.com хаяг дахь Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс үзэх боломжтой.

Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө